УИХ-ын гишүүн

ЦЭРЭНЖАМЦЫН МӨНХЦЭЦЭГ

НЭГ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2020-2021

Гарчиг

4 Мэндчилгээ

5 УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэгийн парламент дахь 1 жил

6 Төрийн түшээгийн "НЭГЭН ОН"-Ы ЦАГЛАБАР

10 ПАРЛАМЕНТ ДАХЬ УЛС ТӨР СУДЛААЧ

13 УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг: Боловсролын тогтолцооны шинэчлэл энэ салбар дахь төсвийн тэгш хуваарилалтаас эхэлнэ

16 Шинэ гишүүний РЕКОРД

19 Эрүүдэн шүүлтгүй Монгол

22 Хүний эрхийн төлөөх тэмцэл хоосон лоозон биш

25 Ц.Мөнхцэцэгийн спортыг дэмжих ЛОББИ

28 Сүхбаатар дүүрэгт шийдсэн төсөл, хөрөнгө оруулалтын ажлууд

30 Сонгогдсон тойрог дахь эргэх холбоо

37 Хөл хориотой ч ХИЛ ХЯЗГААРГҮЙ ажилласан нэг жил

42 МАН-ын мөрийн хөтөлбөр биелэж эхэллээ

Эрхэм хүндэт Сүхбаатар дүүргийн иргэд, сонгогчид оо!

Нийслэл хотын оюун мэдлэгийн түүчээ болсон Сүхбаатар дүүргийн иргэд, сонгогчид Та бүхэндээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Сүүлийн нэг жилийн хугацаа бидний хувьд хүндхэн жил болж өнгөрсөн ч "Ковид-19" цар тахлын эсрэг нэгэн сэтгэлээр нэгдэж, хамтын хүчээр даван туулж байгаад талархал илэрхийлье.

Миний бие нийгмийн тэгш бус байдлыг багасгах, нийгэмд шударга ёсны засаглалыг бий болгоход хувь нэмрээ оруулахын төлөө иргэд та бүхнээ төлөөлөн УИХ-д сонгогдон ажиллаж байна.

Дээрх зорилгодоо хүрэхийн тулд боловсролын тэгш бус байдлыг арилгаж, нийгмийн цөөнх, аль нэг хэсэгт давуу тал олгохгүй, тэгш хүртээмжтэй боловсролыг хүүхэд бүрт олгохын төлөө боловсролын салбарт онцгойлон анхаарч Монголын боловсролыг шинэчлэх гол хуулийн ажлын хэсгийг ахлан ажиллаж байна.

Мөн хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог сайжруулах үүднээс Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн Ажлын хэсгийг ахалж, УИХ-аар батлууллаа. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд миний бие 4 хуулийн төслийн Ажлын хэсгийг ахалж, батлуулсан бөгөөд нийт 6 хууль санаачилж ажиллалаа.

Мөн Сүхбаатар дүүргийнхээ иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах үүднээс Сэлбэ голын далан байгуулах, Сэлбийн эрэг дагуу амралтын цогцолбор байгуулах санхүүжилтыг тойргоос сонгогдсон гишүүдийн хамт шийдүүлж чадлаа. Иргэдийн орон сууц, сургууль, цэцэрлэгийн тохижилт, хүүхдийн тоглоомын талбай байгуулах, олон улсын стандартад нийцсэн жишиг автобусны буудал барих ажлыг эхлүүлээд байна.

Цаашид та бүхнийхээ улс орон, хот, дүүргийн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замын талаарх санал, хүсэлтүүдийг хүлээн авч төрийн бодлогын түвшинд шийдвэрлэн ажиллахын төлөө улам хичээн зүтгэх болно.

Хүндэтгэсэн

Улсын Их Хурлын гишүүн

Цэрэнжамцын **МӨНХЦЭЦЭГ**

Цэрэнжамцын
мөнхцэцэг

Блиц

Монгол Улсын Их Хурлын гишүүн

Хууль зүйн байнгын хорооны гишүүн

Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүн

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын байнгын хорооны гишүүн

Хүний эрхийн дэд хорооны гишүүн

УИХ дахь МАН-ын бүлгийн гишүүн

МАН-ын удирдах зөвлөлийн гишүүн

Парламентын бүлэг

Монгол Европын холбооны парламентын бүлгийн дарга

Монгол Германы парламентын бүлгийн дэд дарга

Монгол Японы парламентын бүлгийн гишүүн

Монгол Америкийн парламентын бүлгийн гишүүн

Монгол Австралийн парламентын бүлгийн гишүүн

УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэгийн парламент дахь 1 жил



Санаачилсан хууль: 6

Хуулийн төслийн ажлын хэсэгт ажилласан: 9

Гишүүнчлэлтэй Байнгын хорооны тоо: 3

Тойрогтоо хийсэн уулзалт: 60

Лобби бүлгийн гишүүнчлэл: 2

Хуулийн төслийн ажлын хэсгийн ахлагчаар ажилласан: 4

Тойргийн сонгогчдоос ирсэн өргөдөл: 200

Шийдвэрлэсэн өргөдөл: 182

Төрийн түшээгийн “НЭГЭН ОН”-ЫН ЦАГЛАБАР

УИХ-ын гишүүний бүрэн эрхийн дөрвөн жилийн хугацаа гэдэг хэрхэн ажиллах учраа олоогүй нэгэнд нь хэтэрхий урт. Хийж хэрэгжүүлье, шийдэл гарц эрэлхийлж шийдвэр гаргах түвшинд үр бүтээлтэй ажиллана гэсэн зорилго өвөртөлж, иргэдийн итгэлийг тээж тангараг өргөсөн төрийн түшээгийн хувьд нүд ирмэхийн зуурт улиран өнгөрөх хугацаа биз ээ. Тийм л сэтгэлээр УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэгийн завгүй ажиллаж өнгөрөөсөн парламент дахь анхны жилийнхээ ажлын тайланг сонгогч түмэндээ дэлгэж байна. Дашрамд дурдахад Ц.Мөнхцэцэг ес дэх парламентын ангид анх удаагаа сонгогдсон гишүүдийн нэг болов намар, хаврын нэгдсэн чуулганыг ирцээрээ тэргүүлсэн, анх удаагаа сонгогдсон гишүүд дундаас хамгийн олон хуулийн төслийн ажлын хэсгийн ахлагчаар ажилласан Улсын Их Хурлын гишүүн юм.

Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлын хэсэгт гишүүнээр ажиллав.

2020.10.28

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэгт гишүүнээр ажиллав.

2020.12.16

Музейн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэгт гишүүнээр ажиллав.

2020.12.16

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн ажлын хэсгийг ахлан ажиллав.

2020.12.28

УИХ-ын гишүүн **Ц.МӨНХЦЭЦЭГ:**

“Алсын хараа-2050” гэдэг бол Монгол Улсын хөгжлийн үндсэн хууль гэж хэлж болно. Үүнийг ямар ч нам, улс төрийн хүчин, ямар ч дарга, сайд байсан мөрдөж, хэрэгжүүлдэг байх нь улс орны хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулна”

Өдрийн сонин 2021.01.28

Цахим орчинд хүний эрхийг хамгаалах тухай хуультай болох саналыг гаргалаа.

2021.01.13

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлыг хэсгийг ахлав.

2021.02

Авлигын эсрэг эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хуулийн биелэлтэд хяналт тавих, холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэх "Авлигын эсрэг лобби бүлэг"-ийг нэр бүхий 5 гишүүний хамт байгуулав.

2021.02.24

Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ажлын хэсгийн ахлагчаар ажиллав.

2021.02.02

Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлын хэсгийг ахлав.

2021.02

ШИНЭ БҮТЭЭЛ, АШИГТАЙ ЗАГВАР, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ПАТЕНТЫН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

1 шинэ бүтээлийн патент нь анхдагч огнооноос хойш 20 жил;

2 ашигтай загварын патент нь анхдагч огнооноос хойш 10 жил;

3 бүтээгдэхүүний загварын патент нь анхдагч огнооноос хойш 15 жил.

Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр эмэгтэй гишүүд бид Хүүхэд хамгааллын болон Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүд өргөн барилаа.

2021.03.08

Монгол Улсын шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсэгт гишүүнээр ажиллав.

2021.03.15

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн Ажлын хэсгийн ахлагчийн хувиар талийгаач Ш.Алтантуяагийн аав С.Шаарийбуутай уулзаж, хилийн чанадад эрх нь зөрчигдөж буй иргэдээ хамгаалах, улс хоорондын эрх зүйн гэрээ, зохицуулалтын талаар ярилцлаа.

2021.03.31

Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилт, салбарын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаар шалгаж санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийг ахлан ажиллав.

2021.04.27

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлын хэсэгт гишүүнээр ажиллав.

2021.03.15

УИХ-ын гишүүн **Ц.МӨНХЦЭЦЭГ**:

"Олон улсын жишгээр хяналтын түр хороо гэдэг мөрдөн шалгах түр хороог байгуулна. Энэ байгууллага нийтийн ашиг сонирхол бүхий томоохон асуудлуудаар хяналт, шалгалт явуулна. Уг түр хорооны бүрэн эрх, нотлох болон гэрчийг дуудах, шинжээч томилох гэх мэт Олон улсын жишгээр парламентын шүүхийн дайтай ажиллах юм"

Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуулийн хэлэлцүүлэг 2021.07.07

УИХ-ын гишүүн Г.Амартүвшины хамтаар иргэн Т.Чимгээг эрүүдэн шүүсэн асуудлаар УИХ-д нээлттэй сонсгол хийх санаачилга гаргаж УИХ-д хүргүүллээ.

2021.04.08

УИХ-ын гишүүн **Ц.МӨНХЦЭЦЭГ**:

Монгол Улс ардчилалд шилжээд 30 жил болсон. Энэ хугацаанд хүний эрхийн дотоодын болон олон улсын гэрээ, конвенцид нэгдсэн. Хэдий тийм ч бодит амьдрал дээр хүний эрхийн төлөө тэмцэж байгаа иргэдийг айлгах, дарамтлахаас гадна амь насанд нь халдах тохиолдол хүртэл гарсан байдаг. Тиймээс хүний эрхийн төлөө тэмцэгчдээ хамгаалах, тэдэнд хууль зүйн туслалцаа, өмгөөлөл, хамгаалал үзүүлэх олон улсын шинэ механизмыг нутагшуулах шаардлага бий болсон учраас энэ хуулийг баталлаа.

Төрийн ордон хэвлэлийн бага хурал 2021.04.02

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлын хэсэгт гишүүнээр ажиллав.

2021.06.29

УИХ дахь эмэгтэй гишүүдийн бүлгээс "Хүүхэд хамгааллын зардлыг нэмэх" шаардлага хүргүүллээ.

2021.07.01

УИХ-аас Номын баяр зохион байгуулах арга хэмжээг албан ёсоор хуульчилж Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэ хуулийг УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг нарын гишүүд санаачилсан билээ. Тэрбээр 30 дахь удаагаа зохион байгуулагдсан "Үндэсний номын баяр"-ыг нээж үг хэллээ.

2021.09.17

"Ковид-19" цар тахлаар өвчилсөн иргэдийн мэдээллийг нууцлах асуудлаар УИХ дахь Хүний эрхийн дэд хорооны гишүүний хувьд ХЭҮК-т албан бичиг хүргүүллээ.

2021.06.30

Сүхбаатар дүүргийн Дамбадаржаад хуучнаар Дендерлогийн төвийн газар дээр сүндэрлэсэн Улаанбаатар хотын хоёр дахь том цэцэрлэгт хүрээлэнгийн гарцны асуудлыг шийдвэрлэлээ.

2021.08.31

Биеийн тамир спортын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих Ажлын хэсгийн ээлжит хуралдаанаар Үндэсний Шигшээ багийн төсвийн санхүүжилт, шигшээ багийг сонгон шалгаруулах журмыг шинэчлэх зэрэг асуудлыг хэлэлцлээ.

2021.09.24



ПАРЛАМЕНТ ДАХЬ УЛС ТӨР СУДЛААЧ

УИХ-ын 2020 оны сонгуулийн кампанит ажил өрнөж байх цаг дор танай өрхийн ширээнээ "Бодлого боловсруулагчаас ШИЙДВЭР ГАРГАГЧ..." хэмээх онцлох нийтлэл бүхий МАН-аас тус тойрогт нэр дэвшигч Ц.Мөнхцэцэгийн сурталчилгааны сэтгүүл заларсныг хэрсүү сонгогч, мэргэн уншигч авхай та тод санаж буй нь гарцаагүй.

Тэгвэл УИХ-ын 2020 оны сонгуулийн үр дүнд бүрэлдсэн парламент бүрэн эрхийнхээ хугацааны нэг жил буюу Намар, Хаврын хоёр нэгдсэн чуулганыг амжилттай хуралдуулжээ. УИХ-ын 8 дахь парламентын ангийг бүрдүүлж буй гишүүдийг ажил мэргэжлийн байдлаар авч үзвэл 14 (18.42%) нь хуульч, эрх зүйч, 21 (27.63%) нь эдийн засагч, 12 (15.79%) нь инженер, агрономич, 14 (18.42%) нь улс төр, нийгмийн ухаан, урлаг, утга зохиолын салбараас, 9 (11.84%) нь эмч, багш, 6 (7.89%) нь бусад мэргэжлийн хүн байна. Энэ дундаас улс төр судлаач мэргэжилтэй гурван гишүүн байгаагийн нэг нь манай тойргоос буюу УИХ-ын сонгуулийн 24 дүгээр тойрог, Сүхбаатар дүүргээс МАН-аас сонгогдсон Цэрэнжамцын Мөнхцэцэг юм.

Улс төр судлаач, доктор **Ц.Мөнхцэцэг**, *"...Миний бие ард иргэдийнхээ дунд олон жил судалгаа хийж, иргэдийнхээ тулгамдаж байгаа олон асуудлыг шийдэх арга замыг боловсруулж УИХ-ын хууль, хөтөлбөрүүдэд бодлогын зөвлөмж өгч ажиллаж ирсэн. Энгийнээр хэлбэл шийдвэр гаргагчдад бодлого боловсруулж өгдөг байсан. Харамсалтай нь өмнөх парламентын ангийн гишүүд мэргэжлийн судлаач бидний санал зөвлөмжийг умартаж өөрсдөдөө ашигтай байдлаар хууль батлах явдал удаа дараа гарч байлаа. Үнэн хэрэгтээ УИХ-ыг бодлогын мэргэжилтнүүд, салбар бүрийн бодлого тодорхойлох чадвартай хүмүүс бүрдүүлэх нь зөв юм. Тийм ч учраас төрийн бодлогын салбарт мэргэшсэн судлаачийн хувьд өөрийн биеэр шийдвэр гаргах түвшинд гар бие оролцож, Монгол Улсынхаа хөгжилд хувь нэмрээ оруулах нь зүйтэй гэж үзлээ..."* хэмээн УИХ-д нэр дэвших шийдвэр гаргаснаа товч тодорхойлж байсныг эргэн сануулья.

Түүний хувьд их улс төрд хөл тавихаар шийдэхдээ хэд, хэдэн томоохон зорилгыг бодит ажил хэрэг болгохоор зориглосноо хэнээс ч нуудаггүй. Нэгдүгээрт, боловсролын тэгш хүртээмжийг бий болгож, нийгэм дэх боловсролын ялгаанаас

үүдэлтэй тэгш бус байдлыг арилгах. Хоёрдугаарт, улс төрийн орчинг эрүүл болгохын тулд хамгийн их авлигад идэгдсэн институт гэж дүгнэж болох улс төрийн намын шинэчлэлийг хуулийн хүрээнд зохион байгуулах. Гуравдугаарт, хүний эрхийг бүх талаар хамгаалах хуулийн орчинг сайжруулна гэж зорилго тавин ажиллажээ. Энэ зорилтууд өмнө нь улс төрийн судлаачаар ажиллаж байх үеийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудаас нь огт зөрөөгүй юм.

Шинэ гишүүдээс хамгийн олон хуулийн төслийг ахалсан нь Ц.Мөнхцэцэг гишүүн

Үүний нэгэн тод илрэл нь тэрбээр Хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн ажлын хэсгийг ахлан ажиллаж анхны хэлэлцүүлгээс УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлуулж, дээрхи хууль Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөх эрх зүйн орчинг бий болгосон явдлыг нэн тэргүүнд онцолсон нь зүйтэй. Монгол Улсын парламент энэ хуулийг баталснаар ази тивийн орнуудын түүхэнд анх удаагаа Хүний эрхийг хамгаалах хуулийн зохицуулалттай улс болсон юм. Ингэснээр хүний эрхийн үндэсний тогтолцоог бэхжүүлэх, иргэний нийгмийн зүтгэлтнүүдийг хамгаалах, Монгол Улс дахь хүний эрхийн зөрчлийг бууруулах эрх зүйн орчин бүрдэж байгаа билээ.

Өндөр хүлээлт:

Авилгын эсрэг тэмцэл

УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэгт тойргийн сонгогчид нь өндөр хүлээлттэйгээр дэмжиж байгаа нэгэн чухал акц бол нэр бүхий 5 гишүүний

хамтаар "Авлигын эсрэг лобби" бүлэг байгуулсан явдал юм.

"Нэр бүхий зургаан гишүүн авлигын эсрэг лобби бүлэг байгууллаа гээд юуг өөрчлөх юм бэ? Ийм сүржин нэртэй бүлэг байгуулах шинэ зүйл биш шүү дээ? Сонгогчдод таалагдах гэсэн популизм төдий" гэж өнгөц дүгнэх, үл ойшоох хандлага нийгмийн тодорхой хэсэгт байгааг үгүйсгэхгүй. Үнэхээр ч өмнөх найман парламентын ангид авлига, албан тушаалын хэрэгтэй тэмцэх ажлыг улс төрийн гол акцаа болгосон гишүүдийн нэгдэл нэг бус удаа тодорч байсныг санаж байна. Хамгийн гол нь үр дүн буюу гарт баригдаж, нүдэнд харагдах бодит ажлаар л эцсийн эцэст дүгнэнэ. Тэгвэл энэ парламентын ангид байгуулагдсан "Авлигын эсрэг лобби бүлэг"-т итгэж, хүлээлт үүсгэж болох хамгийн том хүчин зүйл нь тус бүлгийг бүрдүүлж буй гишүүд юм. Улс төрийн нам үл харгалзан байгуулагдсан тус бүлэгт хуульчдыг төлөөлж мэргэшсэн парламентч, Хууль зүйн байнгын хорооны даргаар ажиллаж байсан арвин туршлагатай Ж.Сүхбаатар, өмнө нь Хууль зүйн дэд сайдаар амжилттай ажиллаж, туушгай шударга үзэл баримтлалаараа олон нийтэд танигдсан Монголын шилдэг хуульчдын нэг Б.Энхбаяр, эдийн засагчдыг төлөөлж ХҮН-ын дарга Т.Доржханд, Сангийн дэд сайдаар өмнөх Засгийн газрын бүрэлдэхүүнд ажиллаж хэр чадалтай эдийн засагч вэ гэдгээ баталсан Х.Булгантуяа. Сөрөг хүчний төлөөлөл, УИХ-ын дэд дарга С.Одонтуяа. мөн улс төр судлаач, эрдэмтдийг төлөөлж УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг нар багтсан. Аливаа албан тушаал, ёс зүйн асуудалд хутгалдаж холбогдож байгаагүй нэр цэвэр гишүүд Монголын парламентын түүхэнд байгуулагдсан гурав дахь авлигын эсрэг лобби бүлгийг байгуулснаараа УИХ-ын хяналт шалгалтыг чангатгах, Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэх, төрийн оролцоот аж ахуйн нэгжийн эрх зүйн статусыг өөрчлөх зэрэг авилгын эсрэг гол механизмыг шинэчлэхэд анхаарч ажиллана гэдгээ мэдэгдэж хуулийн төслийн шинэчлэлийн ажлуудад идэвхийлэн оролцож байна.

Авлигын эсрэг тэмцэлд ялагдаж яваа монголчуудын хувьд тус лобби бүлгийг авлигын эсрэг тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, нам, төрд үүрлэсэн авлига, албан тушаалын гэмт хэрэгтнүүдэд шударгаар хариуцлага тооцож чадвал үүргээ гүйцэтгэлээ гэж үзнэ. Энэ их хүлээлт, итгэлийг алдахгүй гэж найдаж байна.

УИХ-ын гишүүн **Ц.МӨНХЦЭЦЭГ:**

Шүүхийн тухай хуульд бүх шатны шүүхийн томилгоонууд дахь тодорхой субъектийн нөлөөлөл, улс төрийн болон бусад ашиг сонирхлыг арилгах, шүүхийг мерит зарчмаар томилон бүрдүүлж хараат бус, хариуцлагатай шүүх тогтолцоог бий болгохоор өөрчлөлтүүд хийсэн. Энэ зорилгоо биелүүлж чадахуйц хууль баталсан гэж бодож байгаа.

Өдрийн сонин 2021.01.28

Их өөрчлөлт:

Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэл

Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Монголын улс төрийн намууд дотоод ардчилалтай, үндэсний хэмжээнд бодлого явуулдаг, санхүүжилт түүний тайлан нь олон нийтэд ил байх үндсэн зарчмыг баталсан. Энэ шинэчлэлийн ажлын хүрээнд хийгдэх Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлын хэсгийг Ц.Мөнхцэцэг гишүүн ахлан ажиллаж байна. Энэ удаагийн парламент Улс төрийн намын бодлогын шинэчлэлийг хуулиар зохицуулж, хүчин төгөлдөр мөрдүүлж чадвал Монголын улс төрийн орчинг цэвэр болгож улс төрд үүрлэсэн авлигыг хязгаарлах том хөшүүрэг болж чадна. Дээрхи хуулийн төслийн ажлын хэсгийг ахалж буй гишүүн Ц.Мөнхцэцэг улс төрийн намын чиглэлээр хорь гаран жилийн хугацаанд судалгаа шинжилгээ хийж олон арван эрдмийн бүтээл туурвисан, ХБНГУ болон АНУ зэрэг улс төрийн соёлоор тэргүүлэгч орнуудад сурч боловсорч эрдмийн цол хамгаалсан мэргэшсэн судлаачийн хувьд Монголын нөхцөлд тохирох улс төрийн намын тогтолцоо, санхүүжилтийн хэлбэрийг оновчтой тодорхойлсон хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлж, батлуулна гэдэгт төрийн эрх барьж буй улс төрийн ууган нам, тус намаас сонгогдсон туршлагатай улс төрчид бүрэн итгэсэн учраас түүнд энэ парламентын ангиас боловсруулж батлах хамгийн чухал хуулийн нэгийг даалгаад байна. Түүний хувьд УИХ-д анх удаагаа сонгогдсон, бүрэн эрхийнхээ ердөө нэг жилийг л үдэж буй шинэ гишүүн. Гэсэн хэдий ч түүнд парламентад дасах, төрийн бодлого боловсруулах ажилд дадах хугацаа олгох, хар үгээр хэлбэл "хэлд орох", "хөлд орох"-ыг хүлээх шаардлага байсангүй.

УИХ-ын ээлжилт сонгууль бүрээр нийслэлийн Сүхбаатар дүүрэгт улс төрийн намууд лидерүүдээ, эрдэмтдээ, сайдуудаа нэр дэвшүүлж ирсэн түүхтэй. Тийм ч учраас эл тойргоос "чадваргүй" гишүүн сонгогдож Төрийн ордны босго давж байсан удаагүй. Энэ сайн жишгийг ч Цэрэнжамцын Мөнхцэцэг дагаж, давтаж байна. Эх орны оюуны төв, эрдэм мэдлэгийн түүчээ болсон Сүхбаатарчуудын сонголт алдаагүй байлаа. Хариуцлага үүрүүлж, хамтдаа дэмжин ажиллах гурван жил урд хүлээж байна.

УИХ-ын гишүүн **Ц.Мөнхцэцэг:**

Боловсролын тогтолцооны шинэчлэл энэ салбар дахь төсвийн тэгш хуваарилалтаас эхэлнэ

УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг бол хорь гаруй жил боловсролын салбарт багш, эрдэмтэн, судлаачаар ажилласан, энэ салбарын зовлон, жаргалыг хэнээр ч хэлүүлэлтгүй мэдэх нэгэн. Тэр ч утгаараа боловсролын салбарт хэрэгжүүлэх бодлогын томоохон шинэчлэл, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлд голлон ажиллаж байгаа юм. Түүнтэй УИХ-ын энэ намрын чуулганаар хэлэлцэх Боловсролын тухай багц хуулиудын үзэл санаа, энэ нэг жилийн хугацаанд боловсролын салбарт хийж хэрэгжүүлсэн онцлох ажлынх нь талаар ярилцлаа.

УИХ-ын 2020 оны сонгуулийн үр дүнд бүрэлдсэн энэ парламентын анги, Монгол Улсын Засгийн газраас бүрэн эрхийнхээ хугацаанд хэрэгжүүлэх томоохон хуулийн шинэчлэл, бодлогын өөрчлөлтийн нэгийг боловсролын реформ гэж харж байна. Энэ салбарыг төлөөлж төрд сонгогдсон улс төрчийн хувьд бодлого боловсруулах дээрхи ажилд та ямар үүрэг оролцоотой байгаа вэ?

УИХ-ын 2021 оны намрын чуулганаар хэлэлцэж батлах томоохон хуулийн төсөл бол Боловсролын тухай багц хуулиуд юм. Үүнд Боловсролын тухай ерөнхий хууль, Ерөнхий боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Судалгааны их сургуулийн тухай хууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн тухай хууль зэрэг 5 хуулийн төсөл дээр УИХ-ын 27 гишүүн ажиллаж байна. Миний хувьд Судалгааны их сургуулийн тухай хууль болон Боловсролын тухай ерөнхий хуулийн ажлын хэсгийг ахлан ажиллаж байна. Монгол Улсын Их хурал, түүний дэргэдэх БСШУС-ын байнгын хорооноос томилсон ажлын хэсэг боловсруулж хэлэлцүүлэгт шилжүүлж буй боловсролын салбарт хийгдэх бодлогын энэ том шинэчлэл нь МАН-ын 2020 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Боловсролыг тэгш хүртээмжтэй болгох” цогц ажлын биелэл юм.

Монголын боловсролын салбарын тогтолцоог сууриар нь шинэчлэх асуудал олон жилийн турш яригдаж байна. Харамсалтай нь энэ ажил салбарын сайд шинээр томилогдох, солигдохтой зэрэгцээд орвонгоороо өөрчлөгддөг насжилт богино төсөл хөтөлбөрүүдээс цааш хэтрэхгүй байна шүү дээ?

Боловсролын салбарын нэг онцлогийг бид сайтар ойлгох хэрэгтэй байна. Энэ салбарын хувьд бодлого, хөтөлбөрийн шинэчлэлийн үр дүн богино хугацаанд гардаггүйгээрээ онцлогтой. Үр дүнг харж дүгнэх гэвэл дор хаяж 10-12 жил шаардагддаг.

Ингээд харвал Боловсролын сайд болгон шинэ хөтөлбөр хэрэгжүүлнэ гэвэл сургалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг юм. Тиймээс Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд боловсролын зорилтыг хүн бүрт чанартай боловсрол эзэмших, тэгш боломж бүрдүүлнэ гэж тусгаж таван жилийн хугацаанд тогтвортой бодлогоор хангахаар ажиллаж байна. Нөгөөтээгүүр боловсролын салбарт биелэлээ олох бодлогын реформ дан ганц төсөв мөнгийг нэмснээр шийдэгдчихгүй. Боловсролын чанарын үнэлгээ буюу сурагчийн сурлагын амжилтыг үнэлэх, боловсролын тогтолцоонд хэрэгжиж байгаа сургалтын хөтөлбөрүүд, сурах бичгийн агуулгыг сайжруулах зэрэг асуудлуудаас давхар хамаарна.

“Боловсролыг тэгш хүртээмжтэй болгох” гэдэг утга агуулга таны ярианд олон давтагдаж байгааг анзаарлаа. Өнөө цагт боловсролын хүртээмж тэгш бус болсонд юу нөлөөлж байна вэ? Үүнийг яаж залруулах боломжтой вэ?

Шуудхан хэлэхэд монголын боловсролын тогтолцоо дээрхи зорилттой харшилж байна. Өөрөөр хэлбэл эцэг, эхийн хөрөнгө орлогоос хамаарч хүүхдүүдийн боловсролын чанар хэмжигдэж байна. Үндсэндээ сүүлийн 30 жилд монголын боловсролын тогтолцоо бизнесийн суурьтай болчихсонд оршиж байна. Тодруулбал, бүх нийтийн боловсролын салбарт хувийн сургуулиудын баримталдаг бодлого буюу чадвартай сайн багшийг өндөр цалингаар өөрийн болгодог. Сайн багшийг дагаж тухайн хувийн сургуульд элсэх сурагчдаас өндөр төлбөр авдаг байдал монголын боловсролын системд хор хохирол учруулж байна. Уг нь бол хөдөө орон нутгийн, хотын захын хорооллын сургууль, хувийн өндөр төлбөртэй сургуульд алинд нь ч ялгаагүй чадварлаг багш нар ажиллаж байх бололцоо нөхцлийг хангах нь чухал. Тиймээс боловсрол дахь санхүүжилтийн тэгш байдлыг бий болгохын төлөө анхаарч ажиллаж байна. Өнгөрсөн жилүүдэд улсын төсвийн хөрөнгийн 15-20 хувийг эзэлдэг боловсролын салбарын санхүүжилтыг хүн амын төвлөрөл багатай сум, аймагт сурагчдын тооноос хэт их багтаамжтай барилга байшин барих нэрийдлээр замбараагүй зарцуулж иржээ. Тиймээс газар зүйн байршил, хүн амын нягтаршлыг харгалзан боловсролын санхүүжилтыг хийдэг болно.

Боловсролын салбарт хийгдэх бодлогын томоохон шинэчлэлийн хүрээнд та өөрийнхөө сонгогдсон тойрогт ямар ажлыг хэрэгжүүлж байгаа вэ?

Миний бие боловсролын салбарыг төлөөлж хууль тогтоох байгууллагад сонгогдсон гишүүний хувьд нэн тэргүүнд тойргийнхоо ЕБС-иудад “Боловсролын цахим шилжилт”-ийг эхлүүлсэн. Сүхбаатар дүүргийн төрийн болон хувийн хэвшлийн бүх сургуульд цахим шинэчлэлийн төслийг эхлүүлсэн. Хүүхэд бүр чанартай боловсролыг тэгш хүртээмжтэй авах ёстой. Энэ зорилгын үүднээс миний бие Сүхбаатар дүүргийн багш нартаа зориулж удаа дараагийн сургалтуудыг зохион байгууллаа. Мөн энэ жил их, дээд сургуульд элсэн орох төгсөх ангийн сурагчдад зориулж “ЭЕШ 2021” эрчимжүүлсэн сургалтыг санаачлан хэрэгжүүлж гурван сарын хугацаанд нийт 1800 гаруй сурагчийг хамруулаа. Сүхбаатар дүүргийг “Цахим сургалтын жишиг” дүүрэг болгох ажлын хүрээнд 850 сая төгрөгийн төсөв бүхий сургалтын болон багшийн ажиллах орчин нөхцлийг сайжруулах техник хэрэгслийн хөрөнгө оруулалтын төслийг УИХ-ын гишүүний тойрогт ажиллах төсвөөс гарган хэрэгжүүлж байна. Ингэснээр Сүхбаатар дүүрэг маань Монгол Улсын хэмжээнд цахим сургалтын системд төр, хувийн хэвшлийн бүх сургууль нь бүрэн хамрагдсан анхны дүүрэг болох юм.

Дэлхий нийтийг донсолгосон “Ковид-19” цар тахлын хор уршиг хүн төрөлхтний амьдралын хэв маягийг өөрчилж байна. Нөгөө талаар харвал Монгол Улсын төрийн үйлчилгээ, албан байгууллагуудын худалдаа бизнес гэзд нийгмийн

бүх салбарт бүрэн шилжиж хараахан амжаагүй байсан цахим шилжилтийг эрчимжүүллээ гэж харж байна. Энэ нь боловсролын салбарт ч нөлөөллөө?

Энэ хоёр жилийн хугацаанд үүссэн нөхцөл байдал бүхий л салбарын үйл ажиллагааг цахим руу шилжихээс өөр аргагүй болголоо. Үүнээс үүдэж Монгол орны хувьд хамгийн их хохирсон салбарын нэг нь яалт ч үгүй боловсролын салбар байлаа. Учир нь цар тахлын үеийн хөл хорионы дэглэмд боловсролын байгууллага цахим хэлбэрээр сургалтын хөтөлбөрөө үргэлжлүүлэх, багш нар хичээлээ заах, сурагчид боловсрол олж авахад шаардагдах компьютер, техник хэрэгсэл, интернетийн боломж хүртээмж, цахим орчин дахь боловсролын хэрэглээний программ зэрэг маш олон хүндрэлтэй нүүр туллаа. Миний хувьд сонгогдсон тойргийнхоо хэмжээнд үүсээд буй энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд УИХ-ын гишүүний хувиар үүрэн телефоны үндэсний оператор компаниудад интернет сүлжээний хурдыг сайжруулах, цахим хичээл заах, үзэх үндсэн төлбөр буюу датаны үнийг хөнгөлөх албан хүсэлт тавьсныг Мобиком корпораци нийгмийн хариуцлагынхаа хүрээнд нааштайгаар шийдвэрлэж "Академи" гэх хямд үнийн дүнтэй дата багцыг хэрэглээнд нэвтрүүлсэн. Ингэснээр дан ганц манай дүүргийн гэлтгүй Монголын нийт багш, оюутан, сурагчид их, дээд сургуулиудын цахим хуудас, gmal, zoom, teams, skype, Google education зэрэг сургалтын цахим систем рүү хурдны хязгааргүй нэвтрэх боломжтой болсон.

Гэхдээ цахим сургалт 100 хувь төгс шийдэл биш шүү дээ. Энэ систем зарим сурагчдын сургалтын хоцрогдлын шалтгаан ч болох талтай болов уу?

Яг тийм.Ер нь цаашид боловсролын салбар цахим сургалтыг нэвтрүүлэхдээ нийгмийн бүхий л давхаргын айл өрхийн амьдралын боломж бололцоог харгалзан үзэж байж техникийн асуудлыг цогцоор шийдэхгүй бол нийгэм дэх цахим хуваагдал бий болгох бодит эрсдэл харагдаж байна. Учир нь хэн хурдан интернеттэй нь, хэн интернетийг олон цагаар хэрэглэх боломж, бололцоотой нь, компьютер техник хэрэгсэлтэй нь илүү сурч хөгжөөд явах нөхцөл анзаарагдаж байна. Гэтэл хотын захын сургуулиуд, хөдөө орон нутгийн сургуулиудын сурагчид хичээлээс хоцрогдох бодит эрсдэл энэ хугацаанд мэдрэгдлээ. Тиймээс Монголын төр болзошгүй цахим хуваагдлаас сэргийлэхийн тулд нийгмийн хоцрогдсон бүлэгт дэмжлэг үзүүлэх байдлаар боловсрол дахь нийгмийн тэгш бус байдлыг арилгахад анхаарч ажиллах ёстой. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд Боловсролын тухай ерөнхий хуульд миний бие голлон анхаарч ажиллаж байна.

Уучлаарай, таны санаачлан хэрэгжүүлж байгаа цахим сургалтын систем тань харин ч цахим хуваагдлын шалтгаан болохгүй гэж үү? Нөгөө талаар эцэг, эхчүүдийн зүгээс теле, цахим хичээлийн үр өгөөжид сэтгэл хангалуун бус байна шүү?

Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд Монголын бүх шатны боловсролын байгууллагын сургалт цахимаар явсан. 2019-2020 онд ЕБС-ийн 640 мянга гаруй сурагч, их дээд сургуулийн 140 мянга гаруй оюутан цахим хичээлд хамрагдсан. Энэ хоёр жилийн ажлыг дүгнэхэд Монголын боловсролын байгууллага цар тахлын үеийн нөхцөлд танхимын бус аргаар сургалтын хөтөлбөрөө явуулахад туршлага дутсаныг үгүйсгэхгүй. Тийм учраас цаашид цар тахлаас шалтгаалж боловсролын салбарын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжихээр болбол боловсролын төсөв санхүүжилтэд цахим сургалтад шаардагдах тоног төхөөрөмж, сургалтын зориулалттай хэрэгсэлд тодорхой хэмжээний хөрөнгө төсөвлөх шаардлагатай байна. Мөн орхигдуулж болохгүй нэг асуудал нь цахим сургалтын үед багш нарын ажлын цаг, үнэлгээг өөрчлөх хэрэгтэй байна. Учир нь цахим сургалтын үед багш нар ердийн үеэс 2-3 дахин илүү ачаалалтай ажиллаж байна. Тийм учраас цахимаар болон хагас цахимаар сургалт орж буй энэ үед боловсролын салбарынхны хөдөлмөрийн үнэлгээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Таны тойрогтоо санаачлан эхлүүлсэн "Цахим сургалтын жишиг дүүрэг" болох ажил зөвхөн цар тахлын үед ганц дүүрэгт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ гэж харагдахгүй байна. Энэ ажлын тань ололттой талыг Боловсролын яам бодлогоор өргөн хүрээнд хэрэгжүүлээд явах боломжтой юу?

БШУЯ-наас 2020-2021 оны хичээлийн жилд цахим сургалтын орчинг бий болгохын тулд IT-гийн чиглэлээр ажилладаг зургаан компанитай гэрээ байгуулж ажилласан. Яамнаас хэрэгжүүлсэн энэ ажилтай зэрэгцээд Сүхбаатар дүүрэгт миний бие санаачлан улсын 24, хувийн хэвшлийн 25 сургуульд цахим системийг нэвтрүүлэх ажлыг хийсэн. Яамнаас хэрэгжүүлсэн ажил тодорхой хэмжээнд удаашралтай явагдсан нь үнэн. Тийм ч учраас Боловсролын сайд Л.Энх-Амгалан миний санаачлан хэрэгжүүлсэн ажлыг эрчимтэй явагдаж байгааг үнэлж, хотын бусад дүүрэгт сургалтын цахим шилжилтийг амжилттай нутагшуулахын тулд манай төсөл дээр хамтран ажилласан технологийн компаниудад хамтран ажиллах санал тавиад явж байна.

Шинэ гишүүний РЕКОРД

Ес дэх парламентад сонгогдсон 76 гишүүний 31 нь УИХ-д шинээр сонгогдсон гишүүд байна. УИХ-ын сонгуулийн 24-р тойрог Сүхбаатар дүүргээс сонгогдсон Ц.Мөнхцэцэг шинэ залуу гишүүдээ олон үзүүлэлтээр манлайлж буй. Жишээ нь байнгын хороод болон Нэгдсэн чуулганд суусан ирцээр тэргүүлэх эгнээнд. Хуулийн төслийн ажлын хэсэгт орж ажилласан үзүүлэлтээр эхний хоёрт. Шинэ гишүүдийн дундаас хууль санаачилсан тоогоор эхний гуравдугаарт. Хуулийн төслийн ажлын хэсгийг ахласан үзүүлэлтээр тэргүүлж байна. Уншигч та бүхэнд Ц.Мөнхцэцэг гишүүний ажлын хэсгийн ахлагчаар нь ажиллаж өнгөрсөн Хаврын чуулганаар батлуулсан дөрвөн хуулийн төслийн ач холбогдлыг товч танилцуулья.

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль

УИХ-ын 2021 оны Хаврын нэгдсэн чуулганаар Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг баталсан. Ингэснээр Монгол Улс Ази тивдээ анх удаа хүний эрх хамгаалагчийг эрх зүйн зохицуулалтаараа зохицуулсан, хүний эрхээ хамгаалж байгаа иргэний нийгмийн байгууллага зэрэг эвлэлдэн нэгдэж буй улс болсон. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль хэрэгждэг 40 гаруй улс бий. Манай улсад 2021 оны 7 сарын 1-ний өдрөөс тус хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн.

Энэхүү хуулийг батлахад Монгол дахь иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллага, хууль тогтоогчид маш их анхаарал тавьсан. Энэ хугацаанд 3-4 удаа хэлэлцүүлэг зохион байгуулжээ.

Манай улс Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуультай болсноор Хүний эрхийн хамгаалагчийн хороо энэ мөрөөр ажиллаж, эрсдэлийн үнэлгээ хийж тухайн хүний эрх хамгаалагчийг хамгаална. Мөн гадаад улсад гэмт хэргийн золиос болсон, эрх зөрчигдсөн иргэн бүртээ тусламж үзүүлэх, тэдгээр иргэдийн эрхийн төлөө тэмцэгч хүний эрх хамгаалагчийг хил хязгааргүй хамгаалах эрхзүйн орчин бүрдсэн юм.

ЗОХИОГЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ОНЦГОЙ ЭРХ:

Эх сурвалж: parliament.mn

Зохиогчийн эрхийн тухай хууль

Зохиогчийн эрхийн тухай хуулийн хувьд анх 1993 онд баталсан бөгөөд нийгэм эдийн засгийн өөрчлөлтөөс шалтгаалан 2006 онд Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль болгон шинэчилсэн байдаг.

Гэвч цахим болон харилцаа холбооны бусад сүлжээ, өргөн нэвтрүүлэг, олон суваг дамжуулагч, дуу хөгжим, дуу авиа бүхий дүрст бүтээлийн эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох, зохиогч, эрх эзэмшигчийн эрхийг төлөөлөн хэрэгжүүлэх хамтын удирдлагын байгууллагын эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, зохиогчийн эрхийн зөвшөөрөл шаардагдахгүй байх онцгой нөхцөлийг нарийвчлан тодорхойлох шаардлага бий болоод байсан учраас тус хуулийг энэ УИХ-ын үед шинэчлэн найруулж хаврын чуулганаар баталсан.

Хуулийн төсөлд шинээр компьютер программын зохиогчийн эрхийн заалтыг оруулж программыг өөрөө санаачлан зохиосон, эсхүл албан үүргийн дагуу туурвисан тохиолдолд зохиогчийн эрхийг эдлэх субьектыг хуулиар тодорхойлохоор тусгажээ. Мөн зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацаа, дүрслэх урлагийн бүтээлтэй холбоотой зохицуулалтыг тодорхой болгож өгсөн.

Түүнчлэн хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хараагүй, сонсголгүй, харааны эсхүл сонсголын бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан тэдний хүртэж болох хэлбэрт шилжүүлэн хуулбарлах, хуулбарыг хил дамнуулан солилцох, нийтэд түгээх болон нийтийн хүртээл болгоход зохиогчийн эрхийг хязгаарлахтай холбоотой зохицуулалт гээд чухал чухал заалт тус хуульд орсон юм.

Патентын тухай хууль

Патентын тухай хуулийг Оюуны өмчийн тухай хуулийн үзэл баримтлал, зохицуулалтад нийцүүлэх, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 141-д “Патентын тухай хуульд Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас өгсөн саналыг үндэслэн патентын эрхийн хамгаалалтыг дэлхий дахины чиг хандлага, Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэн боловсронгуй болгох” гэж тусгасны дагуу энэ хуулийг шинэчлэн найруулж батлуулсан аж.

Хууль шинэчлэгдэн батлагдсанаар шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар болон ашигтай загварыг бүртгэхээс гадна тухайн бүтээлийн онцгой эрхтэй холбоотой асуудлыг зохицуулах, лицензийн гэрээний зохицуулалтыг нарийвчлан тусгасан. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргах зохицуулалтыг шинэчлэх, мөн шүүлт хийлгэх хүсэлт гаргах, шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын бүтээлийг нийтэд мэдээлэхтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгажээ.

Эл хуульд патентаар хамгаалагдсан шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг бусдад лицензийн гэрээгээр ашиглуулах, патентын эрх шилжүүлэх, өв залгамжлуулах, патентаар хамгаалагдсан шинэ бүтээл ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг бусад этгээд зөвшөөрөлгүй ашиглахаас хамгаалуулах, зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг эрхийг патент эзэмшигч эдэлнэ гэж заасан нь хуулийн шинэчлэн найруулсан төслийн ололт болж чадсан.

ХУУЛИЙН ЗОРИЛТ

Энэ хуулийн зорилт нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварт патент олгох, зохион бүтээгч, патент эзэмшигчийн эрхийг хамгаалах, патентаар хамгаалагдсан шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулж, шинийг санаачлах үйл ажиллагаа болон аж үйлдвэрийн хөгжлийг дэмжихэд оршино.

ШИНЭ БҮТЭЭЛ, АШИГТАЙ ЗАГВАРЫН ХАМГААЛАЛТ

Шинэ бүтээл, ашигтай загварыг энэ хуульд заасны дагуу оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас /цаашид “оюуны өмчийн байгууллага” гэх/ олгосон патентаар хамгаална.

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ХАМГААЛАЛТ

Бүтээгдэхүүний загварыг оюуны өмчийн байгууллага нь энэ хуульд заасны дагуу олгосон патентаар хамгаална.

Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль

Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд олон улсын гэрээ, конвенц, Дэлхийн Оюуны өмчийн Байгууллагаас гаргасан заавар, зөвлөмж, Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэн шинэчлэн найруулж батлуулсан. Энэ хууль батлагдсанаар аж, ахуй эрхлэгчид зах зээлд шударгаар өрсөлдөх, бараа, барааны тэмдэгтийг хуурамчаар үйлдэхгүй байх зэрэг эрхзүйн орчин бүрдэж байна. Хууль хэрэгжиж эхэлснээр Монгол Улс дахь бизнесийн үйл ажиллагаа өргөжиж байгаатай уялдуулан аж ахуй эрхлэгчдийг зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс барааны тэмдэгт тавигддаг шаардлагыг Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвецид нийцүүлэн аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгохгүй байхаар зохицуулагдлаа.

Ингэснээр барааны тэмдэг, газар зүйн заалтын мэдүүлэг гаргах болон бүртгэхтэй холбоотой зохицуулалтыг олон улсын чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болголоо. Тухайлбал, барааны тэмдгийн шүүлтийг чанаржуулах, маргааныг түргэн шуурхай шийдвэрлэх зорилгоор мэдүүлгийн шүүлтийн шатанд гуравдагч этгээдээс эсэргүүцэл гаргах боломжийг бүрдүүлсэн.

■

Эрүүдэн шүүлтгүй Монгол

Монгол Улс бол хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлооно гэж эцэг хуулиндаа тунхагласан парламентын засаглалтай, Үндсэн хуульт ардчилсан тогтолцоот орон. Сүүлийн гуч гаруй жил манай улс энэ зарчмыг эрхэм зорилгоо болгож буй. Гэтэл Хүний эрхийн Үндэсний Комиссоос өнгөрсөн 20 жилийн хугацаанд нийт 19 илтгэл гаргаж УИХ-д танилцуулснаас 13 удаагийн илтгэлд нь Монгол Улсад эрүүдэн шүүлт байсаар ирснийг дурджээ. Судалгааны дүн мэдээлэл худлаа хэлэхгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт “Иргэн халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй” гэж заасан. Үндсэн хуулийн дээрхи заалт Монголын төр нийгмийн зүтгэлтэн С.Зориг агсны амь насыг бүрэлгэсэн хэрэгт буруутгагдан яллагдсан Т.Чимгээ, Б.Содномдаржаа нарт ч хамаатай. Учир нь хуулийн энэ хэсэгт “Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй” гэж цагаан дээр хараар бичсэнийг тодотгоё. Энд нэг зүйлийг зориуд сануулья. Иргэн (ялтан) Т.Чимгээ, Б.Содномдаржаа нарын талаар жишээ татаж буй энэ асуудал нь С.Зориг агсны амь насыг хэн бүрэлгэсэн бэ, хэн гэм буруутай вэ гэдгийг тогтоохоос тусдаа сэдэв бөгөөд мөрдөн шалгах явцад хэргийн сэжигтнүүдийн эрхийг ноцтойгоор зөрчсөн эсэх тухай билээ.

Энэ үндэслэлийг гол болгон УИХ дахь Хүний эрхийн дэд хорооны гишүүд болох Ц.Мөнхцэцэг, Г.Амартүвшин нар иргэн Т.Чимгээгийн эрх ноцтой зөрчигдсөн асуудалд ихээхэн анхаарал хандуулж, шийдвэр гаргах түвшинд үе шаттай олон алхмыг хийсэн юм. Хоёр гишүүний энэ чиглэлд санаачилж хийсэн ажлыг “улс төрийн оноо авах арга” гэж дүгнэх нь өрөөсгөл ойлголт. Учир нь С.Зориг агсны амь насанд халдсан хэргийг тойрсон асуудалд нэр холбогдоно гэдэг өөр дээрээ гал дуудсанаас өөрцгүй. Цаанаа маш том нууц, олон том нэр холбогддог улс төрийн захиалгат хэргийн буруутны зөрчигдсөн эрхийн төлөө тэмцэнэ гэдэг УИХ-ын шинэхэн гишүүнээс, тэр дундаа эмэгтэй улс төрчөөс гараад байхааргүй үйлдэл билээ. УИХ дахь Хүний эрхийн дэд хорооны гишүүн Ц.Мөнхцэцэг болон Г.Амартүвшин нар Т.Чимгээгийн эрхийг хангуулахын тулд энэ хугацаанд хийсэн ажлуудыг он дараалын дагуу нэхэн саная. ▶



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Цэрэнжамцын МӨНХЦЭЦЭГ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-02-55, Факс: 32-70-16
E-mail: munkhtsetsegts@parliament.mn
http://www.parliament.mn

2021.03.30 № УИХ-03/2675
танай _____-ны №_____-т

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД Х.НЯМБААТАР ТАНАА

Хүсэлт гаргах тухай

Монгол улсын нэгдэн орсон "Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенцын нэмэлт протокол"-ын 3 дугаар зүйлд "Оролцогч улс бүр үндэсний түвшинд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хорих газар тогтмол очиж байх нэг буюу хэд хэдэн байгууллага байгуулах, томилох, эсхүл хэвээр ажиллуулах үүрэг хүлээнэ" гэж заасан бөгөөд оролцогч улсуудад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага байгуулах үүргийг хүлээлгэсэн билээ.

Нэмэлт протоколд Монгол улс 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр нэгдэн орсноос хойш таван жилийн хугацаа өнгөрсөн ч эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагыг байгуулаагүй байна.

Хууль хяналтын байгууллагын алба хаагчид Үндсэн хууль болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиудыг ноцтой зөрчиж иргэдийн эрх, эрх чөлөөнд халдаж эрүүгийн хэрэг үүсгэсэн, ял оногдуулсан гэх мэт мэдээлэл хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр гарсаар байна.

Тухайлбал, С.Зориг агсны амь насыг бүрэлгэсэн хэрэгт гэм буруутайд тооцогдон хорих ял эдэлж байгаа иргэн Т.Чимгээ, Б.Содномдаржаа нарыг эрүүдэн шүүж байгаа бичлэгийг Улсын Их Хурлын гишүүд болон сэтгүүлч нарт үзүүлсэнээс хойш бүтэн хоёр жилийн хугацаа өнгөрч байхад энэ асуудал шийдэгдээгүй байна.

Иймд УИХ-ын гишүүд бид иргэн халдашгүй, чөлөөтэй байх эрх, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглох, хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй гэсэн Монгол Үндсэн хуульд

2021000061

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Цэрэнжамцын МӨНХЦЭЦЭГ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-02-55, Факс: 32-70-16
E-mail: munkhtsetsegts@parliament.mn
http://www.parliament.mn

2021.04.08 № УИХ-03/2937
танай _____-ны №_____-т

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД Х.НЯМБААТАР ТАНАА

Хүсэлт хүргүүлэх тухай

С.Зориг агсны амь насыг бүрэлгэсэн хэргийн материалыг нууцын зэрэглэлээс гаргах тухай Улсын Их Хурлын гишүүд бидний 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдөр тавьсан хүсэлтийн дагуу Монгол Улсын Засгийн газар шийдвэр гарган уг хэргийн материалыг төрийн нууцаас гаргасанд талархал илэрхийлье.

Засгийн газрын энэхүү шийдвэртэй холбогдуулан дараах хоёр чиглэлээр анхаарч ажиллана уу. Үүнд:

1.Хэргийн материалын бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй, бусад гадны нөлөөллөөс хамгаалах зохих арга хэмжээ авч ажиллах;
2.Иргэд, олон нийт, хэвлэл мэдээлэл, хүний эрхийн төлөө тэмцэгчдэд хэргийн материалтай нээлттэй танилцах, хяналт тавих боломж олгох үүднээс цахим хэлбэрээр нээлттэй байршуулах ажлыг шуурхай зохион байгуулах.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.МӨНХЦЭЦЭГ
Г.АМАРТҮВШИН

газрын бүрэн эрхийн асуудал тул С.Зоригийн хэргийн материалыг нууцын зэрэглэлээс гаргах асуудлыг шийдвэрлэж өгөхийг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.МӨНХЦЭЦЭГ
Г.АМАРТҮВШИН

Иргэн Т.Чимгээг эрүүдэн шүүсэн асуудлаар нийтийн сонсгол явуулахыг шаардлаа

2021.3.15

УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг, Г.Амартүвшин нар "Иргэний эрхийн эсрэг эрүүдэн шүүлтийн нөхцөл байдал" сэдвээр УИХ-д нийтийн сонсгол явуулах хүсэлт гаргаж байгаа талаараа Төрийн ордонд хэвлэлийн бага хурал хийсэн юм.

УИХ-ЫН ГИШҮҮН Ц.МӨНХЦЭЦЭГ: "Эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахын эсрэг конвенц"-ийг 2002 онд, "Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протокол"-ыг 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр соёрхон баталж дагаж мөрдөж байгаа хэдий ч хууль хяналтын байгууллагын алба хаагчид Үндсэн хууль болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиудыг ноцтой зөрчиж иргэдийн эрх, эрх чөлөөнд халдаж эрүүгийн хэрэг үүсгэсэн, ял оногдуулсан гэх мэт мэдээлэл хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр гарсаар байна. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид шүүхийн шатанд эрүүдэн шүүж хэрэг хүлээлгэхийг хориглосон байдаг. Иргэн Т.Чимгээгийн асуудал бол С.Зориг агсны хэргээс тусдаа бөгөөд процессын шатанд хүний эрхийг зөрчсөн гэж үзэж буй тул Монгол Улсын төдийгүй олон улсын хүний эрхийн байгууллагад хандаж байна. Бид хуульд заасан үндэслэлээр нийтийн сонсгол хийхээр албан бичгийг өргөн барьж байна. УИХ бүрэн эрхийнхээ дагуу хүний эрхийн зөрчлийн асуудлаар Нийтийн сонсгол хийх шаардлагатай"

Тухайн хэргийн явцад зарим баримт ил болсон. Тухайлбал, Засгийн газрын тогтоолоор эрүүдэн шүүсэн бичлэг ил болж, эхлээд улс төрч, сэтгүүлчдэд, дараа нь олон нийтэд дэлгэсэн. Тийм учраас УИХ-ын гишүүд нэгдэн уг асуудлаар Нийтийн сонсгол явуулах шаардлагатай. Нийтийн сонсголоос гарсан санал зөвлөмжийг бид Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд

хүргүүлж мөн шаардлагатай хууль эрхзүйн арга хэмжээнүүдийг авна гэдгээ шаардлага хүргүүлсэн хоёр гишүүн онцолсон юм. Ардчиллын баянбүрд гэгдэх Монгол Улсад иргэнээ тэр дундаа эмэгтэй хүнийг эрүүдэн шүүсэнтэй огтхон ч эвлэрч болохгүй гэдэг байр суурин дээр хоёр гишүүний санал нэгдэж олны анхаарлыг хандуулах зоримог алхам хийсэн нь эхний ололт байлаа.

Хүний эрхийн байгууллагуудтай хүчээ нэгтгэв

2021.3.16

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Г.Амартүвшин нар 2021.03.16-ны өдөр Хүний эрхийн үндэсний комисс болон Монголын Эмнести Интернэшнл байгууллагад ажиллаж, хүний эрхийг хамгаалах, эрүүдэн шүүлтээс ангид байх эрхийг хангах асуудлаар санал солилцсон юм.

Т.Чимгээг эрүүдэн шүүсэн, эрхийг нь ноцтой зөрчиж нэр хүндэд нь халдсан явдал бол ил болсон ганц жишээ нь... Асуудлын учир С.Зоригийн агсныг хөнөөсөн ноцтой хэрэгт холбогдсон сэжигтнүүдийг өмгөөлөх явдал огт биш. Эрүүдэн шүүсэн нь илчлэгдэлгүй өнгөрсөн, үүний золиос болсон иргэд хохироод үлддэг явдлыг эцэслэх нь гол зорилго гэдэг нь ойлгомжтой.

ХЭҮК-т ирүүлдэг гомдлын дийлэнх хувьд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний эрхийг зөрчил байгааг хөнддөг. Тухайлбал, 2020 оны байдлаар эрүүдэн шүүлттэй холбоотой 47 гомдол комисст иржээ. Эдгээр гомдлыг харьяалах байгууллагуудад шилжүүлж, шийдвэрлэлтэд нь зөвлөмж, санал өгч ажиллах нь ХЭҮК-т олгогдсон боломжит эрх үүрэг. Учир нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн 22.2-т "Комисс мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн шатанд байгаа болон хянан шийдвэрлэгдсэн эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг, маргааны талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахгүй" гэсэн хуулийн зохицуулалттай учир асуудалд өөр хэлбэрээр оролцох хууль эрх зүйн боломжгүй байдаг нь энэ төрлийн зөрчил арилахгүй байх нэг шалтгаан аж. Тиймээс эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслах зогсооход манай улсад эрүүдэн шүүлтийг тулгах гэмт хэргийг шалгах хараат бус механизмыг байгуулах, прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албыг дахин байгуулах шаардлагатай байна.

Хэргийн материалыг цахим орчинд нээлттэй байршуулахыг хүслээ

2021.4.8

УИХ-ын гишүүн Г.Амартүвшин, Ц.Мөнхцэцэг нар иргэн Т.Чимгээг эрүүдэн шүүсэн асуудлаар УИХ-д нээлттэй сонсгол хийх санаачилга гаргаж УИХ-д өмнө нь хүргүүлээд байсан. Энэхүү нээлттэй сонсголыг хийхийн тулд С.Зориг агсны амь насыг бүрэлгэсэн хэргийн материалыг нууцын зэрэглэлээс гаргах эрх зүйн шаардлага үүсээд байсан юм. Тиймээс уг хэргийн материалыг нууцын зэрэглэлээс гаргах тухай хүсэлтийг Засгийн газарт тавиад байлаа.

Уг хүсэлтийг Засгийн газар хүлээн авч, 2021 оны 3-р сарын 31-ний хуралдаанаараа С.Зориг агсанд холбогдох хэргийн материалыг төрийн нууцаас гаргаж, шийдвэрлэсэн. Тэгвэл үүнтэй холбогдуулан иргэд олон нийтийн дунд уг хэргийн материалтай хэзээ, яаж танилцах вэ гэсэн хүлээлт үүсээд байсан билээ. Мөн хэргийн материал алдагдах вий гэсэн болгоомжлол олон нийтийн дунд байна.

Тиймээс энэ өдөр УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг, Г.Амартүвшин нар Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт хэргийн материалын бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй, бусад гадны нөлөөллөөс хамгаалах зохих арга хэмжээ авч ажиллахын зэрэгцээ иргэд, олон нийт, хэвлэл мэдээлэл, хүний эрхийн төлөө тэмцэгчдэд хэргийн материалтай нээлттэй танилцах, хяналт тавих боломж олгох үүднээс цахим хэлбэрээр нээлттэй байршуулах ажлыг шуурхай зохион байгуулах хүсэлтийг хүргүүлсэн юм.

Төр нийгмийн зүтгэлтэн С.Зориг агсны амь насанд санаатай халдсан хэргийн үнэн мөнийг тогтооход хяналт, шаардлага тавьж ажиллана гэдэг сонгуулийн мөчлөгт тааруулсан улс төрийн тоглолт болох ёсгүй. Түүгээр зогсохгүй хэргийг мөрдөн шалгах явцад тус хэрэгт нэр холбогдогчдыг эрүүдэн шүүж, эрхийг нь ноцтой зөрчсөн үйлдэл баримтаар нотлогдсон бол тэрхэн цаг үеийн улс төрийн тоглолтод ашиглаад түрхэн зуурт олны анхааралд өртүүлээд өнгөрөх нь өөрөө ёс зүйн том зөрчил мөн. Тийм ч учраас Ц.Мөнхцэцэг, Г.Амартүвшин гишүүдийн санаачлагаар эхлүүлсэн эрүүдэн шүүлтийн эсрэг тэмцэл бол хоёр жилийн өмнө нийгмийг цочроосон дуулиан болсон ч тэгсгээд бүдгэрсэн Т.Чимгээ, Б.Содномдаржаа нарын эрхийг ноцтой зөрчсөн асуудалд эргэн анхаарал хандуулаад зогсохгүй Засгийн газрын түвшинд тодорхой шийдвэр гаргуулж чадсанаараа хүний эрхийн төлөөх үр дүнтэй тэмцэл болж чадсан. Энэ тэмцэл одоо ч дуусаагүй байна.

Хүний эрхийн төлөөх тэмцэл хоосон лоозон биш

Өнгөрсөн оны 07 сарын 8-ны өдөр УИХ дахь Хүний эрхийн дэд хороог УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг, Ш.Адьшаа, Д.Ганбат, Ш.Раднаасэд, Ц.Сандаг-Очир, Н.Учрал, Б.Энхбаяр нарын долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. УИХ-ын Хүний эрхийн дэд хороо нь хууль тогтоомж, олон улсын гэрээ конвенциор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй билээ. Ялангуяа жендэрийн тэгш бус байдлыг багасгах, хүүхдийн аюулгүй байдлыг хангах, гадаадад байгаа Монголчуудын эрхийг хамгаалах, тусгай хэрэгцээтэй иргэдийн нийгмийн оролцоо, тэгш боломж зэрэг хүний эрхийн олон чухал асуудлыг анхаарч ажиллахаар байгуулагдсан. УИХ дахь Хүний эрхийн дэд хорооны гишүүн Ц.Мөнхцэцэг энэ хугацаанд өөрөө санаачилсан болон бусад гишүүдийн хамт хүний эрхийг хамгаалах чиглэлд хийсэн алхмуудыг тоймлож байна.

Хуулийн хэрэгжилтэд хяналт тавихгүйгээр хүчирхийлэлтэй тэмцэхгүй

УИХ-ын эмэгтэй гишүүд (2020.09.21) хүүхдийн хүчирхийллийн асуудлаар ЦЕГ, Хүүхдийн байгууллагуудын төлөөлөл, холбогдох албаныхантай уулзаж, мэдээлэл сонслоо.

Энэ үеэр 9 настай охин хойд эцэгтээ зодуулсны улмаас нас барсан байж болзошгүй хэргийн талаар холбогдох байгууллагын албаны хүмүүсээс хуулийн хүрээнд мэдээллийг авлаа. Намрын ээлжит чуулганаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар төлөвлөж буй. Гишүүд Хууль баталсны дараа хэрэгжилтэд нь анхаарч, санхүүжилт, бүтэц зохион байгуулалтыг нь шийдэхгүйгээр цаашид бодит эерэг үр дүн гарахгүй гэлээ. Иймээс Цагдаагийн ерөнхий газар болон холбогдох байгууллагууд Гэр бүлийн хүчирхийлэлттэй тэмцэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиудад саналаа ирүүлж, идэвхтэй хамтран ажиллахыг сануулсан юм.

УИХ-ын эмэгтэй гишүүд ЭХ, НЯРАЙН асуудлаар УОК-т шаардлага хүргүүллээ

Эх, нярайд эрүүл мэндийн иж бүрэн шинжилгээ хийж, эрсдлээс хамгаалах, эрүүл мэндийн байгууллагын журам зааврыг хэрэгжүүлэхийг УИХ-ын эмэгтэй гишүүд шаардлаа.

"Өргөө" амаржих газарт амаржсан эхээс коронавирусийн халдвар илэрсний улмаас ХӨСҮТ-д шилжүүлсэн. Ингэхдээ дотуур өмд, унтлагын хувцас, гэрийн шаахайтай эмнэлгээс гаргаж эх, нярайг эрүүл мэндийн эрсдэлд оруулсан. Үүнтэй холбогдуулан УИХ-ын эмэгтэй гишүүдийн төлөөлөл Шадар сайд Я.Содбаатарт албан шаардлага хүргүүллээ.

Уг шаардлагад дээрх үйлдэл нь Үндсэн хуулийн холбогдох заалт зөрчсөн гэж үзэн, хууль тогтоомж, журам зааврыг зөрчсөн этгээдэд яаралтай хариуцлага тооцох, эх, нярайд эрүүл мэндийн иж бүрэн шинжилгээ хийж, эрсдэлээс хамгаалах, эрүүл мэндийн байгууллагын журам зааврыг хэрэгжүүлэхийг шаардсан.

Ц.Мөнхцэцэг:

Зэвсэгт хүчин дэх цэргийн дэг бол хүний эрхийн маш ноцтой зөрчил

УИХ дахь Хүний эрхийн дэд хороо 2020 оны 4 сарын 6-ны өдөр Зэвсэгт хүчний цэргийн ангиудад удаа дараа цэрэг амиа алдсан асуудлаар Зэвсэгт хүчний жанжин штаб, БХЯ, ХХЕГ, Дотоод цэргийн командлал, ХЭҮК, ЦЕГ, Улсын ерөнхий прокурорын газрын удирдлагуудыг оролцуулан нээлттэй хуралдлаа.

Хуралдаанд УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг байр сууриа илэрхийлсэн юм. Тэрээр хэлэхдээ,

"Зэвсэгт хүчний анги салбарууд дахь хугацаат цэргийн албан хаагчдыг цэргийн дэг нэрийн дор дарамталж, зодож, эрүүл мэнд, амь насанд нь халдах үйлдлүүд удаа дараа гарч байгаа нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг ноцтой зөрчиж буй явдал. Зэвсэгт хүчин дэх дэглэлт бол эрх зүйн хувьд хүнлэг бус харьцаж буй хүний эрхийн ноцтой зөрчил. Мөн жендерт суурилсан хүчирхийлэл юм. Манай зарим иргэдийн дунд цэргийн албан хаагчид цэрэгт дэглэлт байх ёстой гэсэн хэвшмэл ойлголт байдаг. Үүнийг өөрчлөх ёстой. Монгол Улсад Цэргийн дотоод албаны дүрэм гэж бий. Энэ дүрэмд цэргийн дэгийн бүхий л хэлбэрийг халах, цол, хэргэм үл хамааран бүх алба хаагч Монгол Улсын хууль, тогтоомжийг биелүүлнэ гэж заасан байна. Ёс зүй, цэргийн сахилгаа зөрчвөл хариуцлага хүлээнэ. Тэр ч бүү хэл ангийн захирагч ангийн бие бүрэлдэхүүний ёс зүй, зан байдлын тодорхойлолтод санал өгч, ангийн сэтгэл зүйч офицер бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангаж, дарамт шахалтаас ангид байлгах үүрэг хүлээсэн байдаг. Энэ бүхэн бодит байдал дээр яагаад хэрэгжихгүй байна вэ?" хэмээн асууж, Зэвсэгт хүчний удирдлагуудаас бодит гарц шийдэл илэрхийлэхийг шаардсан юм.

Хүний эрхийн мэдрэмжтэй байхын тулд 700 гаруй хуульд хүний эрхийн талаас нь үнэлгээ хийнэ

Төрийн ордны Их танхимд 2021 оны 5 сарын 25-ны өдөр Хүний эрхийг хамгаалагчдын уулзалт зохион байгуулагдсан.

Монгол Улсад хүний эрх, тэгш байдал хэрхэн хангагдаж байгаа, анхаарах асуудал хаана, хэр хэмжээгээр хуримтлагдсан, хүний эрх зөрчигдөхөөс ангид байхын тулд юу хийвэл зохилтой талаар зохион байгуулагдсан уг уулзалтад хүний эрхийг хамгаалагчид, ХБНГУ, ИБУИНХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд нар, НҮБ-ын Суурин зохицуулагч, "Эмнести интернэшнл" байгууллагын төлөөлөл, Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүд оролцсон юм.

Уулзалтаас гарсан гол шийдвэр нь хууль тогтоох үйл ажиллагаа хүний эрхийн мэдрэмжтэй байхын тулд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 700 гаруй хуульд хүний эрхийн талаас нь үнэлгээ хийхээр болсон явдал юм.

Улс орнуудын хүний эрхийн нөхцөл байдалд НҮБ болон олон улсын мэргэшсэн байгууллагуудаас үнэлэлт дүгнэлт өгдөг. "Дэлхийн шударга ёсны төсөл" олон улсын иргэний нийгмийн байгууллагаас эрхлэн гаргадаг Эрх зүйт ёсны индексээр Монгол Улс 2019 онд 0.55 оноо авч 126 орноос 53 дугаарт эрэмбэлэгдэж байсан.

Тэгвэл "Хил хязгааргүй сэтгүүлчид" төрийн бус байгууллагаас эрхлэн гаргадаг Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний 2021 оны индексээр 28.97 оноогоор 180 орноос 68 дугаар байрт орсон. Энэ мэтчилэн боловсролын салбар дахь тэгш бус байдал, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хэр хангагдаж буйг олон улсын байгууллагуудын жагсаалтад 80-аас хойш байрт жагссан үзүүлэлтээс харж болох юм.

Тиймээс Улсын Их Хурал Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийг 2020 оны нэгдүгээр сард, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг 2021 оны дөрөвдүгээр сард баталсан.

Гэхдээ хууль батлах нэг хэрэг. Түүнийг хэрэгжүүлэх нь илүү чухал юм. Хууль хэрэгжүүлэх хүрээнд үүрэг хүлээсэн төр, засгийн байгууллага, ажилтан, албан хаагчаас гадна бүх шатны байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, хүний эрх хамгаалагчдын идэвхтэй оролцоо нэн чухал байгаа юм.

Ковидтой иргэдийг ялгаварлан гадуурхахыг таслан зогсооно

ХЭҮК-оос гаргадаг "Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" УИХ-ын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо 2021 оны 6 сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хийсэн.

Тогтоолын төслийг УИХ-ын нэгдсэн чуулганд эцсийн хэлэлцүүлэгт шилжүүлэхэд дараах асуудлуудыг тусгахыг УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг онцоллоо.

"Коронавирусийн халдвар авсан иргэдийг ялгаварлан гадуурхах, тэр тусмаа орон нутгийн удирдлага, төр засгийн зүгээс ялгаварлан гадуурхаж байгаа асуудлыг хориглох, ийм үйлдэл гаргасан төрийн албан хаагчдад авах арга хэмжээний талаарх тодорхой зохицуулалтыг тусгах. Мөн эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалинг хоёр дахин нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын асуудлыг эрчимжүүлэх, цар тахлын нөхцөлд нэмэгдүүлэх өргөн хүрээний, тодорхой зохицуулалтыг төсөлд тусгах" санал гаргасан.

Ц.Мөнхцэцэгийн спортыг дэмжих ЛОББИ

Өдөр бүр ТЭР улс төрч байдаггүй. Уулын дугуйн тамирчин байх өглөө, өдрүүд ч олон. Хөнгөн атлетикийн тамирчин охин улс төр судлаачийн мэргэжил эзэмшсэн хэдий ч спортод өгсөн зүрх сэтгэлээ өнөөдөр ч орхиогүй явна.

"Хоршоолол" клубын тамирчин Ц.Мөнхцэцэг өдгөө төрийн хүн болсон нь спортын ертөнцөөс хөндийрсэн гэсэн үг биш ээ. Шийдвэр гаргагчийн хувиар төрөөс баримтлах биеийн тамир спортын бодлогод оролцох, Монгол Улсын спортын хөгжилд дэмжлэг болохуйц оновчтой хуулийн орчинг бий болгоход анхааран ажиллаж байна. Ц.Мөнхцэцэг гишүүн УИХ дахь Биеийн тамир спортыг дэмжих лобби бүлгийг санаачлан байгуулснаас гадна, Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийн талаар шалгаж санал дүгнэлт, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн ахлагч, Монголын дугуйн холбооны Дэд ерөнхийлөгчийн үүрэгт албатай.

Аливаа улс орны спортын бодлого үндсэн хоёр чиглэлээр хэрэгждэг. Нэгдүгээрт, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх. Ингэхийн тулд биеийн тамираар хичээллэх спортын зориулалттай барилга цогцолбор, заал танхим, гадаа талбай, дугуйн болон гүйлтийн зам зэрэгт хөрөнгө оруулж бодлогоор дэмжих нь чухал.

Хоёрдугаарт, мэргэжлийн спортыг хөгжүүлэх буюу Монгол Улсын нэрийг тив, дэлхийд гаргах шилдэг тамирчдыг бэлтгэх, түүнд шаардагдах төсөв, хөрөнгө мөнгө, орчин нөхцөлөөр хангахад чиглэдэг.

Тусгаар тогтносон улс үндэстний гадаад орчинд өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэх, жин нөлөөгөө бататгахад спорт маш өндөр үүрэгтэй. Тийм учраас спортын салбарыг хөгжүүлэх бодлого бол дан ганц Төрийн бус байгууллагууд, түүний удирдлагуудын ажил биш юм. УИХ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны үндсэн ажлын нэгэн том чиглэл нь спортын салбар билээ. Ц.Мөнхцэцэг тус байнгын хорооны гишүүний албан үүргээр Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилт, салбарын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаар шалгаж санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийг өнгөрсөн хавраас ахлан ажиллаж байна. ▶

Эрүүл МОНГОЛ хүн-Бүх нийтийн биеийн тамир

Тэрбээр, *“Биеийн тамир, спортын хөгжил гэдэг тив, дэлхийд амжилт гаргаж байгаа хэдхэн тамирчны амжилтаар хэмжигддэг зүйл биш ээ. Тухайн улс үндэстний эрүүл мэнд, бие бялдарын үзүүлттэй салшгүй холбоотой асуудал. Судалгаанаас харахад Монголчууд бид эмийн худалдан авалтад маш их зарлага гаргадаг үндэстэн. Гэтэл өвчилсний дараах зарцуулагдаж байгаа энэ их зардлыг эрүүл мэндээ урьдчилан сэргийлэхэд, тэр тусмаа эрүүл чийрэг байх үндэс болсон дасгал хөдөлгөөн хийх орчин нөхцөлөөр хангахад Төрийн бодлого шийдвэр чухал”* гэсэн бодол, байр суурьтай байдаг.

Энэ бүхэн нь ч түүний сонгогдсон тойрогт бодит ажил хэрэг болох мөч ойртож байна. Тодруулбал, Монгол Улсын Засгийн газар Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэр Сэлбэ голын эрэг дагуу биеийн тамир, спортын цогцолбор байгуулах төсвийг энэ оны зургаадугаар сард шийдвэрлэж өгсөн. Энэ ажлыг урагшлуулахад Сүхбаатар дүүргээс сонгогдсон гурван гишүүний хичээл зүтгэл их байсныг энд дурдах нь илүүц биз ээ. Засгийн газрын санхүүжилттэй бүтээн байгуулалтын ажлаас гадна УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг тойргийнхоо 10 байршилд сагсанбөмбөгийн талбай бүхий тоглоомын талбай байгуулах төсвийг улсын төсөвт суулгаж эхний ээлжинд нийтийн эзэмшлийн талбай бүхий гурван сул байршилд спорт, тоглоомын талбай баригдах гэж байна.

Эрүүл мэнд, бүх нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлд тойрогтоо хийсэн онцлох ажлын нэг нь Сүхбаатар дүүргийн Дамбадаржаад буюу хуучнаар Дендерлогийн төвийн газар дээр сүндэрлэсэн Улаанбаатар хотын хоёр дахь том цэцэрлэгт хүрээлэнгийн гарцны асуудлыг УИХ-ын гишүүний хувиар Нийслэлийн Засаг дарга Д.Сумьяабазарт чухалчлан уламжилсны дагуу шийдвэрлүүлсэн явдал юм. БНСУ-ын Засгийн газрын зуун хувийн хөрөнгө оруулалтаар баригдсан тус цэцэрлэгт хүрээлэн нь дотроо гүйлтийн болон дугуйн зам, сагсанбөмбөг, волейболын талбай бүхий цогц байгууламж аж. Энэ ногоон цогцолбор ашиглалтад орсноор нийслэлийн хойд бүсийн оршин суугчид амарч зугаалах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, цэвэр агаарт спортоор хичээллэх боломжтой болж байгаа юм. Улаанбаатар хотын хэмжээнд газар нутгийн хэмжээгээрээ хоёрт орохуйц уг том байгууламжийг зорин ирэх иргэдэд нэгэн хүндрэл үүсээд байсан нь орц, гарц байгуулах хэсгийн газрыг чөлөөлж өгөхгүй маргаан үүсгэсэн үл ойлголцол байсныг тойргоос сонгогдсон гишүүний хувьд анхаарч ажилласнаар хотын захын оршин суугчдад зориулсан ногоон байгууламжид тухлах боломжийг бүрдүүлж өгчээ.

“ТОП 5” төрлөөр үл хязгаарлагдах их спорт

Сүүлийн үед тив, дэлхийд амжилт гаргасан тамирчдын цалин урамшуулал нэмэгдэж байгаа боловч энэ нь зөвхөн олимпын төрлийн спортын тамирчин, дасгалжуулагч, холбоодод оногдож “ТОП 5” төрлөөс бусад спортын төрөлд төдийлөн хүртээмжгүй байгаа явдлыг арилгах чиглэлд анхаарч ажиллах шаардлагатайг Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг шалгах ажлын хэсгийг ахлан ажиллах явцдаа илүүтэй анзаарчээ. Баримт дурдвал, үндэсний шигшээ багийн төрөл жил бүр нэмэгдэж, төсвийн санхүүжилт ч тэр хэрээр өсч байгаа юм. 2012 онд төсвийн санхүүжилт 3.4 тэрбум байсан бол 2017-2020 онд 21.4 тэрбум болж өсчээ. Төсөв ингэж нэмэгдэж байгаа ч шигшээ багийг сонгон шалгаруулах журмыг шинэчлэх, тамирчдын залуу халааг бэлдэх асуудалд анхаарах, ЕБС-иудаас эхлээд хүүхэд, өсвөр үеийг бэлтгэх, биеийн тамирын боловсролын агуулга, хөтөлбөрийг сайжруулахгүй бол зарим спортын төрлүүд уналтын байдалд ороод байгаа нь бодит үнэн.

Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд сүүлийн үед олноор хичээллэж эхэлсэн шинэ тутам хөгжиж байгаа спортын төрлүүдийг дэмжих шаардлагатай. Гэтэл “ТОП 5”-аас бусад спортын төрлийг жигд хөгжүүлэхэд тулгардаг гол асуудал нь тухайн спортын зориулалтын ордон, байшин савны асуудал байдаг. Засгийн газрын төсвөөр, эс бөгөөс олон улсын байгууллагын санхүүжилтээр ордон барих асуудлаа шийддэг ч нийслэлд газар олддоггүйгээс тухайн спорт холбоод хэвийн үйл ажиллагаа явуулах, цаашдын төлөвлөсөн ажлуудаа амжилттай хэрэгжүүлэхэд хүндрэл үүсдэг. Тэгвэл УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг ажлын хэсэгт нь багтсан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулинд, “Улаанбаатар хотын нягтаршил өндөртэй гол бүсэд зөвхөн эмнэлэг, сургууль, цэцэрлэг, нийтийн амрах талбайд газар олгоно. Үүнээс бусад зориулалтаар газар олгохыг хориглоно” гэж тусгасан. Мөн “Нийтийн эзэмшлийн талбайг гаргахын тулд жил бүрийн улсын төсөвт газар чөлөөлөх зардлыг суулгана” гэх заалтыг оруулж өгчээ. Хуулиар зохицуулснаар нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх болон спортын холбоодын тэмцээн уралдаан зохион байгуулах зориулалтын спортын ордон, заал барих орчин нөхцөл бүрдэж байгаа нь спортын олон төрлийг жигд хөгжүүлэх бодлогын биелэл юм.

“Сүхийн зөгийнүүд”-ийг “Герман машинууд” дасгалжуулна

УИХ-ын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг тэгш боломж, шударга нийгмийг бүтээхэд хувь нэмрээ оруулж, хүүхэд хаана төрөхөөс үл хамаарч боловсролыг тэгш хүртээмжтэй авдаг болгоход онцгойлон анхаарч ажиллаж буй. Иймдээ ч Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны гишүүнээр ажиллаж, үндэсний боловсролын тогтолцоог сайжруулах тал дээр хэдэн хэдэн чухал ажлуудыг санаачилж ажилласан.

Үүнийхээ хүрээнд тэрээр Европарламентын гишүүн Норберт Нойзерын хөгжиж буй улсуудын хүүхдийн хөлбөмбөгийн дэмжлэг болох “KICK FOR HELP” төслийг санаачилж, Сүхбаатар дүүргийнхээ сургуулиудад хэрэгжүүлж эхлээд байна. Эхний ээлжинд Ерөнхий боловсролын 2 болон 16 дугаар сургуулиудын хөлбөмбөгийн багийн өсвөрийн тамирчдад өмсгөл, бөмбөг гардууллаа.

Цар тахлын нөхцөл байдал намжихаар биеийн тамирын багш нарыг ХБНГУ-д мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулахаас гадна Герман улсаас багш нар ирж хүүхдийн хөгжилд хувь нэмрээ оруулахаар болсон гэдгийг хэлэхэд таатай байна.

Мөн УИХ дахь Биеийн тамир, спортын бүлгийн даргын хувьд Монголын өсвөр үеийнхний бие бялдарын хөгжлийг дэмжих, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, эрүүл чийрэг монгол хүн бэлтгэхэд анхаарч, хүүхдийн хөлбөмбөг, хөнгөн атлетик, дугуйн спортыг хөгжүүлэхээр ажиллаж байна.

Сүхбаатар дүүрэгт шийдсэн төсөл, хөрөнгө оруулалтын ажлууд

Тухайн тойргийн сонгогчдын дийлэнхи олонхийн дэмжлэгээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний ажлын үндсэн үүрэг нь хууль санаачлах, хууль боловсруулах, хууль батлалцах мөн түүний хэрэгжилтэд хяналт тавих замаар Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур эрх ашгийг хамгаалах, Монгол Улсын иргэн бүрийн нийтлэг эрх ашигт нийцсэн хууль тогтоомжийг өдөр тутмын амьдралд суулган хэрэгжүүлж хэн бүхнийг хамгаалах эрх зүйн орчинг бий болгоход оршдог. Мөн түүнчлэн сонгогдсон тойргийнхоо тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарч улсын төсөвт шаардлагатай хөрөнгө оруулалтыг суулгаж, сонгогдсон тойрогтоо идэвхитэй ажиллах нь сайн парламентч, сайн улс төрчийн үзүүлэлт яах аргагүй мөн.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 сарын 8-ны хуралдаанаар Сэлбэ голын урсацыг нэмэгдүүлэх, голын эрэг дагуу тохижилт хийх, Сэлбийн голын эх хэсэгт буюу Бэлх, Сэлхэд үерийн хамгаалалтын далан байгуулах 16 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2022 оны улсын төсөвт суулгахаар шийдвэрлэлээ. Энэ төсөл нь УИХ-д Сүхбаатар дүүргээс сонгогдсон гишүүд Монгол Улсын Ерөнхий сайдад онцлон уламжилсан, тойрогтоо зайлшгүй шийдвэрлэх төсөл байлаа.

УИХ-ын гишүүн **Ц.МӨНХЦЭЦЭГ**:

"Сэлбэ голын эх болох Бэлх, Сэлхэд жил бүр борооны улиралд үер, хаврын улиралд шар усны халиа болдог, үүний улмаас Сүхбаатар дүүргийн 18, 20-р хорооны иргэд жил бүр өчнөөн хөрөнгө мөнгө, эрүүл мэндээр хохирч ирсэн. Үерийн улмаас хашааны нүхэн жорлонгийн ус хальж, айлуудын хөрс, тарьсан ногоог бохирдуулж, улмаар хойд гэр хорооллын гүний худгийн ус руу хүртэл нэвчих аюултай байж ирсэн билээ. Тэгвэл энэ асуудлыг шийдэх "Сэлбийн үерийн хамгаалалтын далан барих" төсвийг шийдсэн нь олон иргэдийн аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалах шийдвэр гаргалаа"

БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр СБД-ийн есдүгээр хорооны нутагт "Ногоон нуур-1008 айлын орон сууц" төсөл хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд автозам, зогсоол, ногоон байгууламж, 960 хүүхдийн сургууль, 240 хүүхдийн цэцэрлэг зэргийг барихаар төлөвлөсөн.

Азийн хөгжлийн банк, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалтаар барьж байгаа "Сэлбэ" дэд төвийн 28 МВт хүчин чадалтай дулааны станцын барилгын явц 95 хувьтай байна. Станц 3,000 гаруй айл өрх, 100 гаруй аж ахуйн нэгжийг дулаанаар хангах бөгөөд ингэснээр 3,000 гаруй янданг хэрэглээнээс гаргах юм.

Сүхбаатар дүүргийн ЕБС-иудыг цахимжуулах зорилтын хүрээнд цахим сургалтыг дэмжих компьютер тоног төхөөрөмжөөр хангах 850 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэн тендерийн шатанд явж байна.

850 САЯ ТӨГРӨГИЙН КОМПЬЮТЕР, ПРИНТЕР БУСАД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Сүхбаатар дүүргийн 18 хороонд хүн амын эрүүл мэндэд ээлтэй эко ариун цэврийн байгууламж байгуулахаар төсвийн 1 тэрбум төгрөгийг 2021-2022 оны төсөвт суулган шийдвэрлэлээ.

357 ӨРХӨД ШИНЭ ЭКО АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ БАРИНА

Сүхбаатар дүүргийнхээ иргэдээс ирсэн хүсэлтэд үндэслэн 18, 19, 20 дугаар хорооны 5 байршилд Олон улсын стандартад нийцсэн, аюулгүй тоглох тоглоомын талбай байгуулах ажил 2021-2022 онд хийгдэнэ.

Нийт 5 байршилд тоглоомын талбай байгуулна

18 хороонд 1 байршилд
19 хороонд 2 байршилд
20 хороонд 2 байршилд

Сүхбаатар дүүргийн 18 хорооны нутаг дэвсгэрт олон улсын стандартын жишиг автобусны эцсийн буудал шинээр барих төсвийг шийдлээ. Уг ажил зураг төсөл хийгдэн шат шатны байгууллагаас хянаж хэрэгжихэд бэлэн боллоо.

Нийт 2 байршилд

Бэлх захын хойд талын автобусны буудалд 1
Тоосгоны үйлдвэр автобусны эцсийн буудалд 1

Сүхбаатар дүүрэг 14 хорооны 51-р цэцэрлэг, 35-р сургуулийн гадаад талбайн тохижилтыг нийслэлийн хороодод жишиг байдлаар тохижуулах ажлыг 2021-2022 онд хийхээр төсвийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэлээ.

14 хорооны ЕБС болон цэцэрлэгийн гадна талбайг иж бүрэн тохижуулна

Сонгогдсон тойрог дахь эргэх холбоо

Иргэд сонгогчид төлөөллийн ардчиллын зарчмаар итгэл хүлээлгэн төрд илгээсэн гишүүнээсээ хууль тогтоох дээд байгууллагад ажиллах бүрэн эрхийнхээ хугацаанд идэвхи санаачлагатай байхыг, бүрэн эрхийнхээ хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлаа тогтмол тайлагнахыг, сонгогдсон тойргийнхоо нийгмийн асуудалд хойрго хандалгүй анхаарахыг, эгэл иргэдийн хүсэлт өргөдлийг төрийн байгууллагад уламжилж ЭРГЭХ ХОЛБОО-той ажиллахыг хүсдэг. Хүсэд ч зогсохгүй хүлээсэн үүрэг хариуцлагыг нь сануулж, шахаж шаардах ч эрхтэй. Өөрөөр хэлбэл сонгууль дөхөхөөр сая нэг царайгаа харуулдаг төрийн түшээтэй байхыг хүсдэггүй ээ. Тэгвэл УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг парламентад сонгогдсон эхний нэг жилийн хугацаанд тойрогтоо хэрхэн ажилласныг энэхүү фото сурвалжлагаас бэлэхнээ харж дүгнэж болно.

Бэлх захад нөөцийн махны хүртээмж хомс байна

2020.11.15

Энэ өдөр нөөцийн мах худалдаалж эхэлсэн анхны өдөр “Цалуут импекс” компанийн нэг машин буюу 110 хонь, ямааны гулууз мах Бэлх зах дээр зарагдаж эхлээд 1 цагийн дотор дуусан нөхцөл байдлыг газар дээр нь харж мэдэрлээ. Нөөцийн мах борлуулагдаж эхэлсэн цагаас хоцорч ирсэн иргэд хямдралтай мах худалдан авч чадсангүй. Хүнсний захын лангуун дээр борлуулагдаж буй мах өндөр үнэтэй байгаа нь иргэдийн амьжиргаанд шууд нөлөөлж буйг нөхцөл байдалтай газар дээр нь танилцсан Төрийн түшээдээ иргэд учирлаж байв. Тиймээс нөөцийн махыг хүрэлцээтэй хэмжээгээр худалдаалах боломжийг бий болгох асуудлаар ХХААХҮЯ-д албан ёсны хүсэлт гаргаж өгөхийг Сүхбаатар дүүргийн дугаар хорооны иргэд уламжилж байлаа.

Дүүргийн 1000 өрхөд хүнсний багц хүргүүллээ

2020.12.14

Цар тахлын хүнд үед Сүхбаатар дүүргээс сонгогдсон гишүүдтэйгээ хамтран “Хамтын хүчээр халдвараас сэргийлье” зорилтот аяныг өнгөрсөн өдрүүдэд өрнүүлсэн. Хандив тусламжид өрх толгойлсон эцэг эх, байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, хүнсний талон зэрэг бусад халамжид хамрагдаагүй тусламж дэмжлэг нэн шаардлагатай айл өрхүүдийг хамруулав. Хатуу хөл хорионы үеэр өрхийн орлого 40 хувиар буурч, үүнтэй холбоотойгоор өдөр тутмын хэрэгцээний хомсдол үүссэн нь судалгаагаар тогтоогдоод байгаа. Иймд бид тусламжаа зорилтот хүмүүстээ хүргэхийг зорьж, Нийслэлийн боловсролын хэлтэс, СБД-ийн Халамжийн хэлтэс, дүүргийн МАН-ын хороодтойгоо хамтран ажиллалаа.











Сүхбаатар дүүргийн ЕБС-ийн 1500 гаруй багшийг сургалтанд хамрууллаа

2021.01.22

Сүхбаатар дүүргээс сонгогдсон УИХ-ын гишүүдийн санаачилгаар СБД-ийн Боловсролын хэлтэстэй хамтран хэрэгжүүлсэн дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн ЕБС-ийн багш нарт зориулсан цахим систем, мэргэжлийн заах арга зүйн сургалт амжилттай явагдлаа.

Сургалтад Сүхбаатар дүүргийн ЕБС-иудын 1253 багш хамрагдахаар бүртгүүлснээс давхардсан тоогоор 1500 гаруй багш сургалтанд хамрагдсан байна. Сургалтыг Монгол Улсын шилдэг эрдэмтэн багш нар хими, физик, математик, мэдээллийн технологи болон цахим систем зэрэг хичээлүүдээр явуулж, оролцогч багш нар өөрсдийн сонгосон хичээлүүдээрээ 6 ангид хуваагдан цахимаар хичээллэлээ.

Сургалтын эхний өдөр "ICT Боловсролд зориулсан цогц систем" сэдвийн хүрээнд УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэгийн Боловсрол, Цахим бодлогын Зөвлөх М.Дэлгэрмаа болон Сүхбаатар дүүргийн 45 дугаар сургуулийн математикийн багш Ч.Ганцэцэг нар сургалт явуулав.

УИХ-ын гишүүн **Ц.МӨНХЦЭЦЭГ**:

Өнгөрсөн 30 жилд Монгол Улсын төсөв барилга байшин буюу хатуу дэд бүтэц рүү 70-80 хувь нь орж ирсэн.Багшийн хөгжил, сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, сургалтын технологид маш бага мөнгө зарцуулж ирсэн. Тиймээс санхүүжилтийг шинэчлэх оновчтой болгох ёстой.Боловсролын санхүүжилтийн тодорхой хувийг багшийн хөгжил, технологийн шинэчлэл гэх мэтэд зарцуулахаар хуульчилж өгье.

"Үндэсний ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт хүргэх нь" сэдэвт хэлэлцүүлэг 2020.11.03

Турк улсын ТИКА байгууллагатай хамтран 250 өрхөд хүнсний тусламжийн багц хандивлав

2021.02.09

Ковид-19 цар тахлын тархалтын нөхцөл байдлаас хамаарч хатуу хөл хорио тогтоож буй хүнд цаг үед УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэгийн санаачилгаар Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн яам, Бүгд Найрамдах Турк улсын хамтын ажиллагааны байгууллага ТИКА-тай хамтран Сүхбаатар дүүргийн 250 өрхөд хүнсний тусламжийн багцыг хүргэлээ.

Хатуу хөл хорио тогтоосноос хойш хувиараа хөдөлмөр эрхэлж байсан иргэдийн орлого тасалдаж, амьдралын өдөр тутмын хэрэгцээгээ хангаж чадахгүй, мөн хаяг, бүртгэлийн зөрчлийн улмаас хүнсний талон зэрэг нийгмийн халамжийн тусламжид хамрагдаж чадалгүй үлдсэн өрхүүд тун хүндхэн байдалд байсныг холбогдох төрийн байгууллагуудад уламжилж дээрхи аяныг зохион байгуулав.



Сүхбаатар дүүрэг цахим сургалтын жишиг дүүрэг боллоо

2021.03.02

2020 оны аравдугаар сараас эхлэн Сүхбаатар дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудад цахим шилжилтийн төсөл хэрэгжүүлж эхлээд байгаа билээ. Энэ төслийн хүрээнд Ерөнхий боловсролын 2-р сургууль дээр УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг биечлэн очиж, төслийн явцтай танилцан, багш нартай уулзалт хийлээ. Сүхбаатар дүүрэгт хэрэгжиж буй цахим системийн энэхүү төсөлд төр, хувийн хэвшлийн Ерөнхий боловсролын нийт 49 сургууль хамрагдаж байгаа юм. Төслийн хүрээнд 1228 багш, 23101 сурагчид цахим аккаунт үүсгэж, 8066 ангийг "Google classroom"-д холбоод байна.

Төсөлд хамрагдсан сургуулийн удирдлагууд, багш нарын зүгээс алсын зайнаас мэдээлэл хуваалцан, нэгэн зэрэг ажиллах боломжоор хангагдахын зэрэгцээ сурагчид багшийн хичээлийг нөхөн үзэж, хичээлийн хоцрогдлоо арилгах, дүн мэдээгээ хялбараар гаргаж, багш, сурагч, эцэг эхчүүд байнгын холбоотой ажиллах боломж бүрдлээ хэмээн баяртай байгаагаа эрэлхийлж байлаа.

УИХ-ын гишүүн **Ц.МӨНХЦЭЦЭГ**:

Дан ганц цар тахлын нөхцөлд гэлтгүй бид мэдээлэл технологийн эрин зуунд дижитал хөгжилтэй хөл нийлүүлэн, түүнийг ажил, амьдралдаа ашиглаж, хөдөлмөрийн бүтээмжээ нэмэгдүүлэх шаардлага тулгарч байгаа. Ялангуяа боловсролын салбар нийгмийн шаардлагаас хоцрох ёсгүй юм.

Нийслэлийн ЕБ-ын 2-р сургуулийн багш нартай хийсэн уулзалт 2021.03.02

Сүхбаатар дүүргээс сонгогдсон гишүүд 4 байршилд бие төлөөлөгчийн газраа нээлээ

2021.03.27

Сүхбаатар дүүргээс УИХ-д сонгогдсон гишүүд болох Д.Цогтбаатар, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг нарын "Бие төлөөлөгчийн газар"-ын байрны бэлтгэл ажил дуусч ашиглалтад орлоо. Тус "Бие төлөөлөгчийн газар" нь нийт дөрвөн байршилд буюу Сүхбаатар дүүргийн гэр хорооллын бүсэд 2, орон сууцны хороололд 2 цэгт байрлан үйл ажиллагаагаа явуулж байна. Ингэснээр тус дүүргийн иргэд тойргийн гишүүдээрээ дамжуулан төрд үгээ хэлэх, нийтийн эрх ашиг хөндөгдсөн аливаа асуудлыг төрийн шийдвэр гаргах түвшинд хүргэх бүрэн боломжтой боллоо.

СБД-ийн 6-р хорооны иргэдэд шинээр батлагдсан хуулиудын талаар мэдээлэл өглөө

2021.06.03

Сүхбаатар дүүргийн 6-р хорооны иргэдтэйгээ уулзаж УИХ-ын гишүүн болоод өнгөрсөн нэг жилийн хугацаанд хийсэн ажлуудаа танилцууллаа.

Энэхүү уулзалтаар эрх баригч МАН-ын мөрийн хөтөлбөрийн биелэл Монгол Улсын Засгийн газрын бодлого шийдвэрт хэрхэн тусгагдан хэрэгжиж буйг болон УИХ-аас баталсан шинэ тутам хэрэгжих хуулиудын талаар мэдээлэл өглөө.

“32-ын тойрог”-ийн өрхүүд дахин төлөвлөлтөд хамрагдана

2021.06.04

Сэлбэ голын дагуу спорт амралтын бүс байгуулснаар бидний нэрлэж заншсанаар 32-ын тойргийн ахуй орчин дагаад сайжирна. Түүнээс гадна Сүхбаатар дүүргийн тус хороо нийслэлийн дахин төлөвлөлтөд хамрагдаад байгаа билээ. Иргэд УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэгтэй хийсэн уулзалтын үеэр, “Газраа орон сууцаар шууд солих, аль болох өндөр үнэлгээтэй өгөх, үнийн зөрүүгээс болж орон сууцанд зээлээр ормооргүй байна” гэсэн санал бодлоо чөлөөтэй эрэлхийлж байлаа.

Сүхбаатар дүүргийн ЕБС-ийн багш нарыг шагнав

2021.06.04

Сүхбаатар дүүргийн ЕБС-ийн багш ажилтнуудтай уулзаж боловсролын салбарын шинэчлэл, цахим шилжилтийн асуудлаар ярилцлаа.

УИХ-аар удахгүй хэлэлцэгдэх Боловсролын багц хуулиудын талаар багш нартай санал бодлоо солилцож, хуулийн төслийн үзэл санааг тайлбарлан мэдээлэл өгөв.

Ц.Мөнхцэцэг: *“Миний бие УИХ-ын гишүүний хувьд боловсролын салбар дахь цахим шилжилтийг нэвтрүүлэх чиглэлээр онцгойлон анхаарч холбогдох хууль тогтоомжуудад ажиллаж байгаагийн зэрэгцээ сонгогдсон тойрог болох Сүхбаатар дүүрэгтээ цахим сургалтыг дэмжих 850 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэсэн”*

УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг нь гишүүний тойрогт ажиллах төсвөөс Сүхбаатар дүүргийн төрийн өмчийн 25, хувийн хэвшлийн 24 сургуулийг хамруулсан Цахим сургалтын систем нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлж байгааг Сүхбаатар дүүргийн боловсролын салбарын ажилчид хэдийнэ мэдэх болжээ.

УИХ-ын гишүүн **Ц.МӨНХЦЭЦЭГ:**

Монголын боловсролын салбарт тэгш бус байдал газар авсан энэ үед нийт хүүхдийнхээ 10 хувьд ч хүрэхгүй кембрижийн сургалтыг өргөжүүлэх зардлыг нэмэхийн оронд суурь боловсролын чанарыг нийтэд нь сайжруулах хэрэгтэй. Суурь боловсролыг өгч байгаа улсын сургуулиудын нийт боловсон хүчин, хөтөлбөрүүдээ дэмжээд явья.

УИХ-ын БСШУС-ын байнгын хорооны хуралдаан 2020.08.25

Өндөр үнэтэй эмийн хөнгөлөлтийн журамд өөрчлөлт оруулахаар ажиллаж байна

2021.04.23

Иргэдээс ирсэн хүсэлтийн дагуу Улсын Нэгдүгээр Төв эмнэлгийн удирдлагууд хүнд өвчтөндөө хийх байсан Pfizer вакциныг өөрсдийн хамаарал бүхий хүмүүст хийсэн тухай мэдээлэл болон эрхтэн шилжүүлсэн иргэдэд улсаас олгодог өндөр үнэтэй эмийн тайлан, тооцоонд шалгалт хийх тухайд Авлигатай тэмцэх газарт албан бичиг явуулаа.

Эрхтэн солиулсан иргэдээс УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэгт хаягласан хүсэлт, өргөдлүүдэд улсаас сар бүр өгдөг өндөр үнэтэй эмийн хөнгөлөлтөд тухайн сардаа ямар нэг шалтгаанаар хамрагдаж чадаагүй бол дараа сард нь нөхөж өгдөггүй. Энэ нь тус хөнгөлөлтөд зайлшгүй хамрагдах шаардлагатай иргэдийн эрүүл мэнд, эдийн засагт хүндээр нөлөөлж буй тухай гомдол удаа дараа дурдагдсан байсан юм. Тиймээс Эрүүл Мэндийн Даатгалын Ерөнхий газраас хэрэгжүүлдэг Өндөр үнэтэй эмийн хөнгөлөлтийн журмыг уян хатан болгох, эм олгосон гэх бүртгэлийн жагсаалтыг нээлттэй шилэн болгоход анхаарч ажиллаж байна.



“ЭЕШ 2021” эрчимжүүлсэн цахим сургалтанд 1823 сурагчийг үнэ төлбөргүй хамруулаа

2021.05 сараас -08 сар

Цар тахлын улмаас үүссэн хоёр жилийн хичээлийн хоцрогдлыг арилгахад хувь нэмэр болох, тойргийнхоо төгсөх ангийн сурагчдыг элсэлтийн ерөнхий шалгалтаа амжилттай өгч хүссэн сургуульдаа зорьсон мэргэжлээрээ элсэн суралцах боломжийг бүрдүүлж өгөх зорилготойгоор “ЭЕШ 2021” цахим сургалтыг УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг санаачлан хэрэгжүүллээ. Тус сургалтад Сүхбаатар дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн хүсэлтээ өгсөн 26 сургуулийн 1823 сурагч хамрагдлаа. 2021 оноос анхлан эхлүүлсэн уг сургалтыг математик, англи хэл, нийгмийн ухааны хичээлүүдээр зохион байгуулсан бөгөөд Сүхбаатар дүүргийн Боловсролын хэлтэс болон “EAST Education Academy”-тай хамтран зохион байгуулаа. Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх энэхүү эрчимжүүлсэн сургалт үнэ төлбөргүй байснаараа онцлогтой бөгөөд сургалтын хугацаанд гарсан нийт зардлыг УИХ-ын гишүүний тойрогт зарцуулах төсөвт суулгаж өгсөн юм. ■

Хөл хориотой ч ХИЛ ХЯЗГААРГҮЙ ажилласан нэг жил

УИХ-ын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэгийг улс төр судлаач, улс төр судлалын доктор зэрэгтэй эрдэмтэн, мэргэжлийн улс төрч гэдгийг тойргийн сонгогчид нь төдийгүй олон улсын нэр хүндтэй улс төрийн мэргэжлийн байгууллагууд хэдийнэ хүлээн зөвшөөрсөн билээ. Үүний тод илрэл нь тэрбээр УИХ-ын гишүүнээр сонгогдон ажиллахаасаа өмнө нь Дэлхийн дэвшилтэт намуудын Прогрессив Альянс байгууллагын Удирдах зөвлөлийн гишүүн. Төв ази судлалын Европын нийгэмлэгийн гишүүн. ЮНЕСКО-гийн Нийгмийн өөрчлөлтийн удирдлагын хөтөлбөрийн Үндэсний хорооны гишүүн. НАМЭХ-ны Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан Дэд ерөнхийлөгч гэхчилэн гадаад харилцаа, олон улсын түвшинд ажиллах эрх бүхий олон сонгуульт ажлууд юм.Ц.Мөнхцэцэг УИХ-ын сонгуулийн 24 дүгээр тойргоос сонгогдон төрийн түшээгийн цаг наргүй, өндөр хариуцлагатай ажилд ханцуй шамлан орсон ч гадаад харилцаа, олон улсын түвшинд Монголын парламентыг төлөөлж идэвхи санаачлагатай, нэр хүндтэй ажиллаж байна.



Бүтээлч иргэдээ дэмжинэ

2020.10.26 *(Монгол Европын холбооны парламентын бүлэг)*

Монгол-Европын парламентын бүлгийн даргын хувиар УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг Европын холбоо, МҮХАҮТ-ын хамтран зохион байгуулсан "Европын худалдааны өдрүүд" арга хэмжээнд оролцлоо.

Арга хэмжээний үеэр Европын холбоо болон НҮБХХ-ийн суурин төлөөлөгчтэй санал солилцож, хамтран ажиллахаар боллоо.

Европын Холбоо "Монголын худалдааг дэмжих төсөл"-ийг (EU-TRAM) 2017 оны 3-р сараас (2021 он хүртэл хэрэгжинэ) санхүүжүүлж эхэлсэн ба энэ төслийн хүрээнд ГХЯ, МҮХАҮТ хамтран ажиллаж, Монголын экспортын голлох бүтээгдэхүүн болох чацаргана, арьс шир, ноос ноолууран эдлэл, сарлагийн хөөврөөр брэнд бүтээгчдийг гадаад зах зээлд гарахад дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ экспортын өртөг зардлыг бууруулах, олон улсын зорилтот зах зээл дэх ашигтай ажиллагааг дээшлүүлэхэд нь экспортлогч талуудад бодитой дэмжлэгийг үзүүлэхээр ажиллаж байна.

Монголын туршлага олон улсад сайн жишиг болсон нь...

2020.10.29 *(Монгол Европын холбооны парламентын бүлэг)*

"Asia Europe People's Forum"-аас зохион байгуулсан Ази, Европын улсуудын парламентын гишүүдийн "Ковид-19 цар тахлын үе дэх дэвшилтэт бодлого" хэмээх онлайн хуралд оролцож "Ковид-19 цар тахлыг даван туулах нь: Монгол Улсын жишээн дээр" сэдвээр илтгэл тавилаа.

Монгол Улс бол дотооддоо халдвар алдаагүй дэлхийн ганц улс, цар тахлын нас баралт байхгүй дэлхийн 11 улсын нэг гэдгээр улс орнуудын анхаарлыг ихэд татаж байгаа юм. Мөн цар тахлын нөхцөлд парламентын болон орон нутгийн сонгуулиудаа цаг хугацаанд амжилттай зохион байгуулсан улс учраас бусад улс орнуудын хувьд жишиг болж сайшаагдаж байгаа билээ.

Энэхүү хуралд Ази, Европын орнуудын парламентын гишүүд улс орон, бүс нутагтаа цар тахлын үеэр авч хэрэгжүүлж буй бодлогын талаараа хуваалцаж, оролцогчдын сонирхсон асуултад хариулсан юм.

“People in Need” байгууллагын үйл ажиллагааг дэмжин ажиллана

2020.11.10 *(Монгол Америкийн парламентын бүлэг)*

УИХ дахь Хүний эрхийн дэд хорооны гишүүний хувиар хүний эрх, хөгжлийн тусламжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг People in Need олон улсын байгууллагын суурин төлөөлөгч Тимоти Женкинсийг хүлээн авч уулзлаа.

Гэр хорооллын иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хамтран ажиллахаар боллоо. Энэ ажлын хүрээнд 2020 оны 12 сарын 10-нд болох Олон улсын хүний эрхийн өдрөөр гэр бүлийн хүчирхийллийн эсрэг “Цагаан тууз” аянд оролцох боллоо.

Элгээ дэвсээд угтах эх оронтой Монголчууд

2020.11.23 *(Монгол Германы парламентын бүлэг)*

УИХ дахь Хүний эрхийн дэд хорооны гишүүний хувиар Франкфуртад гацсан иргэддээ тусламж, дэмжлэг үзүүлэх асуудлаар Гадаад харилцааны яам болон Герман дахь ЭСЯ-нд хүсэлт хүргүүллээ.

Албан ёсны фэйсбүүк хуудсаараа дамжуулан Европын орнууд болон Их Британи, АНУ, Туркээс эх орондоо тусгай үүргийн нислэгээр ирэх гэж байгаад нислэг цуцлагдсантай холбоотойгоор тэнд гацсан иргэдтэй холбогдож, мэдээлэл авч нөхцөл байдалтай нь танилцлаа. Энэ ажилд Хилийн чанад дахь монголчуудын холбоо ТББ мөн хамтран ажиллалаа.

Ийнхүү санал авч эхэлснээс хойш зөвхөн Франкфуртын нислэгт суух байсан иргэд төдийгүй гадаад улс оронд цар тахлын хүнд нөхцөлд байгаа 150 гаруй хүн хандаж хүсэлт ирүүлснээс Франкфуртад гацсан иргэдийн хүсэлтийг шийдвэрлүүлэхээр Гадаад хэргийн яам болон УОК-т хүргүүлж цаг алдалгүй шийдвэрлүүлж чадлаа.

Ардчиллын үр дүнг улс төрийн намаас ангид авч үзэх аргагүй

2021.01.29 *(Монгол Америкийн парламентын бүлэг)*



АНУ-ын Стэнфордын их сургууль, МУИС-ийн хамтран зохион байгуулсан “Ази болон Монгол улс дахь ардчиллын сорилт: Зөвлөлдөх ардчилал, онлайн парламент, сонгуулийн шинэчлэлээр дамжуулан инновацы хийх нь” бага хурлын хоёр дахь өдрийн хуралдааныг нээж үг хэллээ.

“Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд өрнөж буй авторитари хандлага, популизмын сэргэлт дэлхий дахины ардчиллын үйл явц болон улс төрийн намуудад ихээхэн сорилт учруулж буй нөхцөлд 2019 оны 11 сард Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр парламентын засаглалаа бэхжүүлж чадсан Монгол дахь ардчилсан дэглэмийн бэхжилтэд урт хугацааны эерэг үр дүн авчирч байна.

Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу батлагдах хуулиудын нэг нь Улс төрийн намын тухай хууль юм. Улс төрийн намын төлөвшилт нь улс төрийн үйл явц, ардчиллын бэхжилтэд шууд нөлөө үзүүлдэг учир Монголд төлөвшиж буй ардчиллын үр дүнг улс төрийн намаас ангид авч үзэх аргагүй юм.

Тийм учраас Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр улс төрийн намын үйл ажиллагаа, санхүүжилтыг боловсронгуй болгох чухал алхмуудыг хийсэн билээ. Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй иргэд эвлэлдэн нэгдэж байгуулан, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллах, намын дотоод зохион байгуулалт нь ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө орлогын эх үүсвэр, зарцуулалт нийтэд ил тод байна гэж заасан юм.

Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн энэхүү үзэл баримтлалын дагуу УИХ Улс төрийн намын тухай хууль, Улс төрийн санхүүжилтын тухай хуулиудыг шинэчлэн батлаж улс төрийн намын шинэчлэлийг хийж чадвал Монголын ардчиллын бэхжилтэд томоохон хувь нэмэр оруулах болно” гэдгийг гишүүн хурлын хоёр дахь өдрийг нээсэн үгэндээ дурдлаа.

Хуралд АНУ, ХБНГУ, Их Британи, Япон, БНСУ болон Монголын эрдэмтэн судлаачид оролцож ардчилал, улс төрийн нам, сонгуулийн үйл явцын талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

Япон Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй боловсролын салбарын төсөлтэй танилцлаа

2021.02.26 *(Монгол Японы парламентын бүлэг)*

Япон Улсын Засгийн газрын "МОНГОЛ УЛСЫН ЕБС-ИЙН БАЙГАЛИЙН УХААНЫ СУРГАЛТЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ НЬ" төслийн хүрээнд бүтээж буй сургалтын хэрэглэгдэхүүнийг танилцуулах үйл ажиллагаанд урилгаар оролцлоо.

Японы болон МУБИС-ийн эрдэмтэн багш нар физикийн хичээлд ашиглах инновацид суурилсан 10 гаруй нэр төрлийн электрон багажуудыг бүтээсэн байна. Эдгээр бүтээлүүдээ төсөлд хамрагдсан хот хөдөөгийн сургуулиудад нийлүүлж, туршилтаа эхлүүлжээ. Мөн багш нарыг сургагч багшаар бэлтгэсэн сайхан мэдээ байна.

Цаашдаа төслийн багийнхан шинэ технологи ашиглан ЕБС-ийн байгалийн ухаан, физикийн кабинетын үнэ өртөг, овор ихтэй, олдоц ховор электроник автоматжуулалтын төхөөрөмжүүдийг бүтээх юм байна.

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны үнэ цэнэ

2021.03.07 *(Монгол Японы парламентын бүлэг)*

Монгол дахь японы элчин сайдын яамтай хамтран "Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны үнэ цэнэ" онлайн хэлэлцүүлэг" зохион байгууллаа.

АНУ-ын Элчин сайдтай улс төрийн намын төлөвшил сэдвээр санал солилцлоо

2021.03.09 *(Монгол Америкийн парламентын бүлэг)*

АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Майкл Клеческигийнд зочилж улс төрийн намын төлөвшил, хүний эрх, авлигын эсрэг хийх үйл ажиллагаа, англи хэлний боловсролын талаар хамтран ажиллах тухайд ярилцлаа.

Европын Холбоо УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэгийн хүний эрхийн төлөөх тэмцлийг сайшаалаа

2021.03.31 *(Монгол Европын холбооны парламентын бүлэг)*

УИХ дахь Монгол-Европын Холбооны парламентын бүлгийн гишүүдээ төлөөлж УИХ-ын гишүүн Г.Амартүвшингийн хамтаар Европын Холбооноос Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Траян Лауренцю Христеатай уулзаж Европын Холбооноос 2021-2027 онд Монгол Улсад хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн талаар ярилцлаа.

Элчин сайд Траян Лауренцю Христеа УИХ дахь хүний эрхийн хууль тогтоомжууд, Ц.Мөнхцэцэг нарын Хүний эрхийн дэд хорооны гишүүдийн эрүүдэн шүүхийн эсрэг хийж буй санаачилгыг анхааралтай ажиглаж дэмжиж байгаагаа илэрхийллээ. Тэр дундаа УИХ-д хэлэлцэгдэж буй Хүний эрх хамгаалагчийн хуулийн үзэл баримтлалын талаар ярилцлаа.

Ирэх жилүүдэд Европын холбооноос “Ногоон, тогтвортой хөгжил”, “Ардчилал, эдийн засгийн хөгжил”, “Ногоон эрчим хүч” гэсэн гурван үндсэн чиглэлээр урт хугацааны хөтөлбөрүүд хэрэгжүүлэх юм.

Ардчилал, эдийн засгийн хөгжил хөтөлбөр нь хууль эрхзүйн салбарын чадавхыг бэхжүүлэх замаар тус салбарын шинэчлэл хийх, авлигатай тэмцэх хуулийн хэрэгжилтийг сайжруулах, иргэний боловсролыг дэмжих, хүний эрхийн асуудлыг хамрах юм. Энэ хүрээнд Монгол Улс дахь эрүүдэн шүүхийн эсрэг механизмыг боловсронгуй болгох, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын конвенциудын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх талаар Европын холбоотой хамтран ажиллахаар болов. Мөн авлигатай тэмцэх асуудлын хүрээнд УИХ дахь Авлигын эсрэг бүлэгтэй хамтран ажиллах, бүс нутгийн болон олон улсын түвшинд авлигын эсрэг үйл ажиллагаа, санаачилгуудад идэвхтэй оролцоход дэмжлэг үзүүлэх тухайд саналаа уламжиллаа.

Европын Холбооны урт хугацааны хөгжлийн хөтөлбөр нь бүс нутаг, хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжих, нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, агаарын болон хөрсний бохирдлыг багасгах, сэргээгдэх болон ногоон эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх, эмэгтэйчүүд, хөдөөгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьжиргааг дэмжих, ажлын байр бий болгох зэргээр өргөн хүрээг хамарч байгаа юм.

Цар тахал хийгээд үл зогсох СПОРТЫН ЕРТӨНЦ

2021.04.16

Нийт найман орон, олон улсын нэг байгууллагын төлөөлөл оролцсон “Биеийн тамирын боловсрол”, “Спортын анагаах ухаан, сургалт дасгалжуулалт”, “Спортын маркетинг, менежмент”, “Цар тахлын үеийн биеийн тамир, спорт” гэсэн 4 үндсэн чиглэлээр 39 илтгэл хэлэлцүүлэх цар хүрээ өргөнтэй олон улсын хурлын нээлтэд Монгол Улсын Их Хурал дахь Биеийн тамир спортыг дэмжих бүлгийн даргын хувьд УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг үг хэллээ.

Тэрбээр илтгэлийнхээ эхэнд:

“Дэлхий дахинд Ковид 19 цар тахал нүүрлэсэн энэ цаг үед, Токио 2021 олимпын өмнөхөн болж байгаагаараа энэ удаагийн хурал онцлогтой болж байна. Цар тахлын улмаас дэлхийн улс орнуудын олон салбарт хүндрэл гарч байна, тэдгээрийн нэг нь спортын салбар билээ. Орчин үеийн олимпын түүхэнд анх удаа энхийн цагт Ковид-19 цар тахлаас болж зуны олимп хойшилсон үйл явдал боллоо. Цар тахлын хатуу хөл хорионуудын улмаас тамирчдын бэлтгэл сургуулилт тасалдах, хязгаарлагдах, тэмцээн уралдаанууд цуцлагдах болсон хүнд цаг үед Биеийн тамирын боловсрол, спортын хөгжлийн талаар олон улсын эрдэмтэн судлаачид ийнхүү хуралдаж, цар тахлын үеийн спорт, цаашдын хөгжил, спортын анагаах ухаан, сургалтын талаар ярьж байгаад УИХ дахь Биеийн тамир спортыг дэмжих бүлгийн тэргүүний хувьд баяртай байна. Монгол Улсын төрөөс биеийн тамир, спортыг дэмжих тухайд онцгойлон анхаарч, нэгдүгээрт, нийтийн биеийн тамирыг дэмжиж эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгох, хоёрт, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлэх гэсэн хоёр үндсэн чиглэлээр бодлого явуулж байна” хэмээн онцолсон юм.

Цар тахал дэлхий дахины тэгш бус байдалд хэрхэн нөлөөлөв?

2021.04.29

Олон Улсын Парламентын Холбооны ээлжит 142 дугаар Ассамблейн бэлтгэл ажлын хүрээнд зохион байгуулагдаж буй цахим хуралдааны 3 дахь өдрийн цахим хуралдаанд оролцож “Цар тахал дэлхий дахины тэгш бус байдалд хэрхэн нөлөөлж байна вэ?” сэдэвт илтгэлийг тавилаа.

Цар тахал дэлхий дахины тэгш бус байдлыг гүнзгийрүүлж байна. Үүнд, ажлын байрны тэгш бус байдал, цахим хуваагдалт, вакцинжуулалт, цар тахлын сөрөг нөлөө эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд хүндээр нөлөөлж байгаа зэргийг УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг илтгэлдээ онцолж байлаа.

Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн хамгаалал, зохистой цалин хөлс, татварын шударга тогтолцоо зэрэг бодлогуудыг хэрэгжүүлж чадаагүй улс орнууд Ковид-19 цар тахлын нөлөөнд хамгийн их нэрвэгдэж байна. Тийм ч учраас улс орнуудын төр, засаг цар тахлаас сургамж авч, шударга тогтолцоо, хүнлэг нийгмийг бий болгож, сайн сайхан маргаашийг бүтээх ёстойг сануулаа.

“Авлигын эсрэг лобби бүлэг” АНУ-ын ЭСЯ-тай хамтран ажиллана

2021.05.12 *(Монгол Америкийн парламентын бүлэг)*

УИХ дахь Авлигын эсрэг лобби бүлгийн гишүүд Ж.Сүхбаатар, Х.Булгантуяа, Т.Доржханд бид АНУ-ын элчин сайд Майкл Клечиски, АНУ-ын USAID-н захирал Гарри Роббинс болон ЭСЯ-ны ажилтнуудтай уулзаж, авлигын эсрэг хамтран ажиллах талаар ярилцлаа.

“Гуравдагч хөрш”-ийн бодлого гадны хөрөнгө оруулалтын түлхүүр

2021.05.18 *(Монгол Европын холбооны парламентын бүлэг)*

Монгол-Европын парламенттай харилцах бүлгийн даргын хувьд Европын Парламентын Төв Ази, Монгол Улстай харилцах бүлгийн дарга ноён Фулвио Мартучиллотой цахим уулзалт хийлээ.

Монгол Улс Европын Холбоо болон түүний гишүүн орнуудтай харилцах харилцааг өндрөөр үнэлдэг бөгөөд Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд парламент хоорондын түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхийн төлөө ажилладаг билээ. Монгол Улсын урт хугацааны зорилго бол Европын Холбоо болон түүний гишүүн орнуудтай харилцах харилцаагаа өргөжүүлэх, худалдаа, хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх замаар соёл, иргэд хоорондын харилцааг бэхжүүлэхэд оршдог.

Евростандартыг жижиг дунд үйлдвэрлэлд нэвтрүүлнэ

2021.09.07 *(Монгол Германы парламентын бүлэг)*

УИХ дахь Монгол-Германы парламентын бүлгийн Дэд даргаар УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг ажилладаг. Энэ сонгуульт ажлын хүрээндээ Герман-Монголын бизнес эрхлэгчдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүний ажлыг давхар хашдаг юм. 2021 оны 9 сарын 7-ны өдөр тус холбооны ээлжит хуралдаан боллоо.

Хуралдааны үеэр хоёр улсын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг эрчимжүүлэх, бизнесийн харилцааг тэлэх талаар харилцан санал солилцлоо.

Герман Монголын Бизнес эрхлэгчдийн холбооны ерөнхийлөгч Евро-Хаан ХХК-ийн захирал Оливер Шнорр цар тахлын хүнд нөхцөлд Монгол Улсын Засгийн газраас эдийн засгаа дэмжих, ажлын байрыг хадгалах, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, авлигын индексийг бууруулах тухайд онцгой чармайлт гарган ажиллаж байгааг онцоллоо. Мөн Карлсруэ, Кёльн хотуудын худалдааны танхимтай хамтран ажиллаж, тус хотуудын бизнесийн салбарынхныг Монгол Улсад тогтвортой үйл ажиллагаа явуулах, харилцаа холбоо тогтоох ажлуудыг эхлүүлээд байгаа баярт мэдээг хуваалцлаа.

Харин УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг Монголын жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг ХБНГУ болон Европын зах зээлд гаргахад гол саад бэрхшээл болж буй Евростандартыг нэвтрүүлэх, холбогдох эрх зүйн зохицуулалт, хууль тогтоомжийг шинэчлэх тухайд парламентын гишүүний хувьд анхааран ажиллахаа илэрхийлллээ. ■

МАН-ын мөрийн хөтөлбөр биелэж эхэллээ

УИХ-ын 2020 оны ээлжит сонгуульд МАН хөрөнгө мөнгөөр биш, хөгжлийн бодлогоор өрсөлдөх зарчмыг дэвшүүлж "Хөгжлийн гэрээ" мөрийн хөтөлбөрийг боловсруулж, нэр дэвшигчдээ ард олны хүлээлтэд тулгуурлан нэр цэвэр, мэдлэг боловсролтой, ажлын туршлагатай байх шалгуураар тодруулсан. Тэр ч утгаар ард иргэд, сонгогчид анх удаа Монгол Ардын Намд дараалан Засгийн эрх барих боломжийг олгосон нь улс орныхоо хөгжлийг урагшлуулах томоохон боломж, нөгөө талаас өндөр хариуцлага оногдуулсан явдал болсон. Тэгвэл 2020-2024 он хүртэлх бүрэн эрхийн хугацааны эхний нэг жилд эрх баригч намын мөрийн хөтөлбөрийн биелэл ямар түвшинд явааг хамтдаа дүгнэцгээе!

"Үдийн цай"-г "Үдийн хоол" болголоо

МАН-ын 2020 оны УИХ-ын сонгуулийн хөтөлбөрийн 1.4.9-д "ЕБС-д үдийн цай хөтөлбөрийг үргэлжлүүлж, үдийн хоолны үйлчилгээг үе шаттайгаар хэрэгжүүлж, нэг хүүхдэд ногдох зардлыг 2 дахин нэмж, шим тэжээл, амин дэмээр баялаг хоолоор үйлчилнэ" гэж амласны дагуу Засгийн газар 2021-2022 оны хичээлийн шинэ жилээс эхлэн "Үдийн цай" хөтөлбөрийг "Үдийн хоол" болгож, нэг хүүхдэд ногдох зардлыг нэмэх шийдвэр гаргалаа.

Боловсролын үйлчилгээ хүүхэд бүрт тэгш хүртээмжтэй байж, хүүхэд бүр эрүүл чийрэг өсөхөд Үдийн хоол хөтөлбөр ихээхэн чухал юм.

Цэцэрлэгүүд хоёр ээлжийн багштай боллоо

МАН-ын Мөрийн хөтөлбөрийн 1.4.7-д "Цэцэрлэгийн бүлэг бүрт 2 ээлжийн багш ажиллуулан хүүхэд хүлээж авах, өгөх цагийг уртасгаж эцэг, эхчүүдэд ажлаа тараад хүүхдээ авдаг боломжийг бүрдүүлнэ" гэж амласны дагуу 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн цэцэрлэгүүд хоёр ээлжийн багштай болж байна.

Эхний ээлжинд энэ хичээлийн жилд 6 дүүргийн 25 цэцэрлэгт 60 багш туршилтаар ажиллуулах шийдвэрийг Засгийн газраас гаргалаа. Ингэснээр цэцэрлэг 07.30-19.00 цаг хүртэл, өдөрт 12 цагаар ажиллана. Үүний үр дүнд эцэг эхчүүд хүүхдээ цэцэрлэгээс авах гэж яарахгүй ажлаа тайван хийх боломжтой болж байна.

Суурь боловсролыг тэгш хүртээмжтэй болгоно

МАН-ын 2020 оны УИХ сонгуулийн мөрийн хөтөлбөрийн 1.4.21-д хувийн цэцэрлэг, сургуулийг ашгийн, ашгийн бус гэдгээс хамаарсан бодлого хэрэгжүүлж, ашгийн бус сургалтын байгууллагыг бодлогоор дэмжинэ гэж заасан. Хувийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хүүхэд элсүүлэх журам, сургалтын төлбөр тогтоох аргачлалыг тэгш, хүртээмжтэй, хүүхдэд хохиролгүй, ялгаварлахгүй байх зарчмаар эргэн харж, эрх баригч намын мөрийн хөтөлбөрийн энэ амлалтыг хэрэгжүүлэхээр БШУС-ын сайд Л.Энх-Амгалан тэргүүтэй яамны удирдлагууд хичээн ажиллаж байна. Энэ ажлын эхлэл болгож өндөр төлбөртэй хувийн сургуулийн хувьсах зардлын санхүүжилтыг зогсоолоо.

Шударга ёсны засаглал бий болгох амлалт хуулиар баталгаажсан нь...

Монгол Ардын Нам 2020 оны УИХ-ын сонгуульд оролцохдоо шударга ёсны засаглал бий болгох амлалтыг ард түмэндээ өгсөн билээ. Тэгвэл энэ амлалтаа биелүүлэх, Монгол Улсад шударга ёсыг бий болгох, иргэн бүр шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангах Шүүхийн тухай хуулийг УИХ-ын 2021 оны хаврын нэгдсэн чуулганаар УИХ-ын гишүүдийн дийлэнх олонхиор эцэслэн баталлаа.

Шүүхийн тухай хууль бол 2020 оны сонгуулиар бүрдсэн УИХ-ын бүрэн эрхийн хугацаан дахь тогтолцооны шинэчлэлийг хийх хамгийн гол хуулиудын нэг юм. Эрх зүйт төрийн үндсэн зорилго нь шүүхийн хараат бус байдлыг хангах замаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах явдал учраас Шүүхийн шинэчлэлийн үндсэн зорилго үүнд чиглэж байна. Тэгвэл энэ зорилгыг хангахад шүүхийн томилгоо чухал нөлөөтэй байдаг.

Тийм учраас Шүүхийн тухай хуулинд бүх шатны шүүхийн томилгоонууд дахь тодорхой субьектийн нөлөөлөл, улс төрийн болон бусад ашиг сонирхлыг арилгах, шүүхийг мерит зарчмаар томилон бүрдүүлж хараат бус, хариуцлагатай шүүх тогтолцоог бий болгох, Шүүхийн ерөнхий зөвлөл, Сахилгын хороог улс төрөөс хараат бус, мэргэжлийн байх зарчмаар сонгон бүрдүүлэхээр зааж өгсөн юм.

“Хуримтлалын нэгдсэн сан” нийгмийн хүлээлт

МАН 2020 оны УИХ-ын сонгуульд оролцохдоо мөрийн хөтөлбөрийн суурь үзэл баримтлалаа “Амьдралын чанар ба дундаж давхарга” хэмээн зарлаж, нийгмийн бүх салбарт тэгш бус байдлыг багасгаж, дундаж орлоготой иргэдийн тоог нэмэгдүүлэх замаар амьдралын чанарыг дээшлүүлэх зорилт тавьсан билээ.

Энэ зорилтдоо хүрэхийн тулд:

Нийгмийн даатгалын шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, “Хуримтлалын нэгдсэн сан” байгуулан иргэн бүр нэрийн дансандаа бодит хуримтлалтай болох тогтолцоог бий болгоно.

Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулан иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэнэ.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлж, уул уурхайгаас олох үр шимийг Баялгийн сангаар дамжуулан иргэн бүрд тэгш, шударга хүртээх тогтолцоог бүрдүүлнэ.

Баялгийн сангийн тухай хууль гаргаж, сангийн засаглалын зохистой зарчмуудыг тодорхойлох дүрэм, журмыг батлуулна гэсэн амлалтуудыг ард түмэндээ өгч, ард түмэн МАН-ын мөрийн хөтөлбөрийг дэмжин итгэл хүлээлгэсэн билээ.

МАН-ын сонгуулийн хөтөлбөрийн энэхүү амлалтуудыг хэрэгжүүлэх бодлогын ажлууд ид явагдаж байна. Иргэдийн орон сууцжуулалтыг нэмэгдүүлэх, хуримтлалын нэгдсэн сан, үндэсний баялгийн санг бүрдүүлэх, дундаж давхаргыг тэлэх үндэсний хорооны анхдугаар хурал 8 сарын 27-ны өдөр боллоо.

Үндэсний баялгийн сангийн тухай, Нийгмийн даатгалын багц хууль, Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулиуд удахгүй УИХ-аар хэлэлцэгдэж, МАН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн суурь заалтууд биелэлээ олох цаг мөч ойртож байна. ■

УИХ-ын гишүүн

ЦЭРЭНЖАМЦЫН

МӨНХЦЭЦЭГ

Холбоо барих хаяг:
Төрийн ордон 413

www.muki.mn

facebook.com/MunkhtsetsegPhD

twitter.com/@mpmunkhtsetseg

УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэгийн Ажлын албанаас эрхлэн гаргав